# ХӨВСГӨЛ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

## Мөрөн сумын газар олголт, ашиглалтын байдал

## ХөААГ – НАБ/2015/01-ГА

Аймгийн ИТХ-ын захиалга, аймгийн Аудитын газрын
2015 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөө,
хөтөлбөрийн дагуу гүйцэтгэсэн гүйцэтгэлийн аудитын тайлан



**ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ ЗӨРЧИН ГАЗАР ОЛГОЖ БАЙНА.**

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХӨВСГӨЛ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2015 оны 09 сарын 10 өдөр — Дугаар А/30 — Мөрөн

Аудитын тайлан баталгаажуулах тухай

МУ-ын Ерөнхий аудиторын 2014 оны 121, Аймгийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2015 оны 04 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Мөрөн сумын газар олголт, ашиглалтын байдал"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Гүйцэтгэлийн аудитын тайланг Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг дарга, Мөрөн сумын Засаг дарга, Мөрөн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллан үр дүнг 2015 оны 12 дугаар сарын 15-ны дотор багтаан аймгийн Аудитын газарт ирүүлэхийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Т.Болдбаатар, аймгийн Засаг дарга А.Эрдэнэбаатар, Мөрөн Засаг дарга Ц.Гансүх, Мөрөн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Л.Цэгмэд, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга Н.Бямбадорж нарт зөвлөсүгэй.

4. Зөвлөмжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аудитын менежер Г.Эрдэнэчимэг, ахлах аудитор Б.Тэгшдэлгэр нарт даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.ОЮУНГЭРЭЛ

Doc_tushaal

07 056

**АГУУЛГА**

**Тайланг бэлтгэсэн:**
**ХөААГ-ын Нийцлийн аудитын баг**

***Тэргүүлэх аудитор***
*Г.Оюунгэрэл*
*Утас: 96665871*

***Аудитын менежер***
*Г.Эрдэнэчимэг*
*Утас: 99016320*

***Багийн ахлагч :***
*Ахлах аудитор*
*Б.Тэгшдэлгэр*
*Утас: 99089114*

***Багийн гишүүн:***
*Ахлах аудитор*
*Л.Энх-Амгалан*
*Утас: 96383478*
*Аудитор*
*Л.Магсаржалам*
*Утас: 88114867*
*Шинжээч*
*Б.Сандуйжав*
*Утас: 99380020*
*Шинжээч*
*А.Ууганбаяр*
*Утас: 88866993*
*Шинжээч*
*Э.Бат-Эрдэнэ*
*Утас: 99857609*

**2015 оны 9 дугаар сар**

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70384043 дугаарын утсаар харилцана уу.

***ХАЯГ*:**
**Мөрөн сум Аймгийн ЗДТГ-ын “А” корпус 3 давхар**

Товчилсон үгийн жагсаалт
Аудитын зорилт, хамрах хүрээ, арга зүй

**Бүлэг 1. Газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтгүйгээр газар олгосоор байна.**

1.1 Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг аргачлалын дагуу боловсруулаагүй байна.
1.2 Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг зөрчин газар олгосон байна.
1.3 Газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт явуулахгүйгээр газар олгосоор байна.
1.4 Төрийн байгууллага, албан газрын эзэмшлийн газрыг бусдын эзэмшилд хууль зөрчиж шилжүүлсэн байна

**Бүлэг 2. Газар эзэмшиж, ашиглаж байгаа аж ахуйн нэгж байгууллагууд 2013-2014 онд 48,0 сая төгрөгийн газрын төлбөрөө төлөөгүй байна.**
2.1 Иргэнд газар өмчлүүлэх ажил хуульд заасан журмын дагуу явагдаж байгаа боловч төрийн байгууллагын зүгээс иргэнд “газар өмчлүүлэх ажил”-ыг идэвхижүүлэх шаардлагатай байна.
2.2 Газрыг зориулалтын дагуу ашиглахгүй байна.
2.3 Газрын төлбөрийг орон нутгийн орлогод бүрэн төвлөрүүлэхгүй байна.
2.4 Газар олголт болон газрын төлбөр ногдуулалт, төвлөрүүлтэд тавьж буй хяналт үр дүнгүй байна.

**Бүлэг 3. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 63%-ийн гүйцэтгэлтэй байна.**

3.1 Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан боловч үр дүн гаргаагүй байна.
3.2 shilendans.gov.mn сайтад мэдээллийг Засгийн газрын 2014 оны 384 тоот тогтоолоор баталсан “Журам”-д заасан агуулга, нийтлэг стандартад нийцүүлэн цаг хугацаанд тавьж хэвшээгүй байна.

Дүгнэлт

Зөвлөмж

Холбогдох байгууллагын санал

Саналд өгсөн тайлбар
Хавсралт

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

| | |
|---|---|
| **МУ** | Монгол Улс |
| **ЗГ** | Засгийн газар |
| **ХөААГ** | Хөвсгөл аймгийн Аудитын газар |
| **НАБ** | Нийцлийн аудитын баг |
| **ГА** | Гүйцэтгэлийн аудит |
| **ГХБГЗЗГ** | Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газар |
| **ИТХ** | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| **ЗДТГ** | Засаг даргын тамгын газар |
| **ХБХ** | Хөгжлийн бодлогын хэлтэс |
| **СТСХ** | Санхүү төрийн сангийн хэлтэс |
| **ГХБХБГ** | Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар |
| **МХГ** | Мэргэжлийн хяналтын газар |
| **УБХ** | Улсын бүртгэлийн хэлтэс |
| **ААН** | Аж ахуйн нэгж |
| **ХХК** | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| **МХХЕТ** | Мөрөн хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө |
| **ТЖГЗБТ** | Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө |
| **МТ** | Магнай трейд |
| **ШТС** | Шатахуун түгээх станц |
| **ХАА** | Худалдан авах ажиллагаа |
| **ОНХС** | Орон нутгийн хөгжлийн сан |
| **ХДТ** | Хөгжимт драмын театр |
| **УБ** | Улаанбаатар |
| **ЭДЦС** | Эрдмийн далай цогцолбор сургууль |
| **БТСГ** | Биеийн тамир, спортын газар |
| **РӨНС** | Радио, өргөн нэвтрүүлэх станц |
| **ШШГА** | Шүүхий шийдвэр гүйцэтгэх алба |
| **БОГХГЗЗ** | Байгаль орчин, газрын харилцаа, геодези, зураг зүй |

## Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аймгийн ИТХ-ын захиалга, аймгийн Аудитын газрын 2015 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлийн аудит хийв.

Аудит нь дараах зорилтын хүрээнд шалгалт хийж, дүгнэлт гарган зөвлөмж өгөх, үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад чиглэгдсэн. Үүнд:

- Газрыг хууль, журмын дагуу олгож байна уу?
- Газрын эзэмшилт, ашиглалт, өмчлөлт үр дүнтэй байна уу?
- Өмнөх аудитаар илэрсэн зөрчил арилсан эсэх, зөвлөмжийн биелэлт болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт үр дүнтэй байна уу?

Аудитад Мөрөн сумын 2013 он, 2014 он, 2015 оны 6 дугаар сарын байдлаарх газар олголт болон газар ашиглалтын байдал, аймгийн ИТХ, ЗДТГ-ын ХБХ, СТСХ, ГХБХБГ, Мөрөн сумын ИТХ, ЗДТГ, Татварын хэлтэс, МХГ, УБХ, иргэн, ААН хамрагдлаа.

Аудитын төлөвлөлт болон санхүүгийн тайлангийн аудит, урьдчилсан судалгаа, түүнд хийгдсэн дүн шинжилгээ, харилцагч байгууллагуудын холбогдох албан тушаалтантай хийсэн ярилцлага, бусад баримт, тулган баталгаажуулалтыг үндэслэн ерөнхий эрсдэлийг **“ДУНД”** гэж үзлээ.

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт, шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашигласнаас гадна холбогдох газруудад аудитын горимын дагуу асуудлыг шинжлэн судлах, асуулга, ярилцлага хийж аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн шалгалтын журамд заасны дагуу дэмжлэг болох нотлох зүйлс, мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад хамрагдсан хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дараах хууль, эрх зүйн акт, баримт бичгийг аудитын шалгуур болгон ашигласан. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Байгууллагын нууцын тухай хууль
- Хувь хүний нууцын тухай хууль
- Газрын тухай хууль
- Газрын төлбөрийн тухай хууль
- Хот байгуулалтын тухай хууль
- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хууль
- Кадастрын тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль
- Засгийн газрын 2013 оны 179-р тогтоол
- Засгийн газрын 2014 оны 179-р тогтоол
- Засгийн газрын 2003 оны 28-р тогтоол
- Засгийн газрын 1997 оны 152-р тогтоол
- ЗТБХБСайдын 2010 оны 206-р тушаал

- Холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд

Гүйцэтгэлийн аудитыг хийхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх журам, гүйцэтгэлийн шалгалтын журам, Тэргүүлэх аудиторын баталсан гүйцэтгэлийн аудитын төлөвлөгөөг удирдлага болгон ажиллалаа.

Гүйцэтгэлийн аудитыг Тэргүүлэх аудитор Г.Оюунгэрэл удирдаж, аудитын менежер Г.Эрдэнэчимэг арга зүйгээр ханган, явцын хяналт тавьж, Ахлах аудитор Б.Тэгшдэлгэр, Л.Энх-Амгалан, Аудитор Л.Магсаржалам, Шинжээч Б.Сандуйжав, А.Ууганбаяр, Э.Бат-Эрдэнэ нар 2015 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс 2015 оны 9 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэлээ.

Бүлэг 1

ГАЗРЫН ДУУДЛАГА ХУДАЛДАА, ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТГҮЙГЭЭР ГАЗАР ОЛГОСООР БАЙНА

### 1.1 Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг аргачлалын дагуу боловсруулаагүй байна.

Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө нь оновчтой эсэхийг газар зохион байгуулалтын үндсэн баримт бичигт тусгасан ерөнхий төлөвлөгөөнүүд[1] болон газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах аргачлалтай[2] тулган шалгахад дараах байдалтай байна.

*Газар зохион байгуулалтын үндсэн баримт бичигт тусгасан ерөнхий төлөвлөгөөтэй нийцүүлсэн байдал:*



Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлд аймаг, сумын ИТХ-ын нийтлэг бүрэн эрхийг тусгасан бөгөөд 20.1.2-д *“Тухайн шатны Засаг даргын өргөн мэдүүлсэн аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, түүнд нийцүүлэн боловсруулсан сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэлэлцэн батлах”* гэж заасан байна. Энэхүү бүрэн эрхээ хэрэгжүүлсэн эсэхийг авч **үзэхэд:** Аймгийн ИТХ-ын 2013 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн ээлжит 5 дугаар хуралдааны 10 дугаар тогтоолоор аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулахад 158.0 сая төгрөг зарцуулахаар шийдвэрлэсэн бөгөөд 2014 оны 06 дугаар сарын 05-ны өдөр “Газар дэлхий” ХХК-тай Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг 149.5 сая төгрөгөөр[3] боловсруулахаар гэрээ байгуулсан байна. Тус компани гэрээний дагуу төлөвлөгөөг боловсруулсан бөгөөд захиалагч тал аймгийн ИТХ-ын 2015 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн ээлжит бус 11 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан байна.

Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний тухайд: Аймгийн ИТХ тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг сүүлийн 3 жил батлаагүй бөгөөд Мөрөн сумын 2013, 2014[4], 2015 онуудын газар зохион байгуулалтын төлөвлөгөөг */Инженерийн шугам, сүлжээ бүхий газрыг оруулсан/* Мөрөн сумын ИТХ баталсан байна.

[1] Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үе шатны төсөл
[2] ГХБГЗЗГ-ын даргын 2010 оны 497 дугаар тушаалаар баталсан “Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах аргачлал”
[3] 2014 онд 79.0 сая төгрөг, 2015 онд 70,5 сая төгрөг баталсан байна.
[4] 2014 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар эцэслэн батлуулахаар шийдвэрлэсэн ч Тэргүүлэгчдийн хурлаар батлуулаагүй Мөрөн сумын ИТХ-аар батлуулсан байна. “Сүүлийн 3 жилийн ГЗБТ-г ГХГЗЗГ-аас ирүүлсэн албан бичгийн дагуу Мөрөн сумын ИТХ-аар батлуулсан” гэж ГХБХБГ-ын мэргэжилтэн Ж.Жавзанпагма тайлбар өгсөн болно.

Энэ нь Газрын тухай хуулийн 21.3.2-г зөрчиж аймгийн Засаг дарга аймгийн ИТХ-д өргөн мэдүүлж, батлуулах газар зохион байгуулалтын төлөвлөгөөг сумын ИТХ баталсныг харуулж байна.

Дээрх байдлаас **харахад:** 2013, 2014, 2015 онуудын газар зохион байгуулалтын төлөвлөгөө нь нийцүүлэх ерөнхий төлөвлөгөө байхгүйгээс газар нутгийнхаа нөөцөд тулгуурлан боловсруулагдсан гэж үзэж байна.

Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг Мөрөн хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулж байгаа талаар авч **үзэхэд:**

Газрын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д *"Хот, тосгон бусад суурины газарт иргэн, аж ахуйн нэгж байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглуулах үйл ажиллагааг зөвхөн тухайн хот, тосгон, бусад суурины харьяалах засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг үндэслэн боловсрогдож батлагдсан* ***хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, түүнд тулгуурласан үе шатны болон хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу энэ хуульд заасан журмаар хэрэгжүүлнэ****"* гэж заасан байна.

Аймгийн ИТХ-ын 2012 оны ээлжит бус 12 дугаар хуралдаанаар Мөрөн хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг баталсан ч уг төлөвлөгөөний талаар аймгийн **ГХБХБГ-ын мэргэжилтэн Ж.Жавзанпагма:** "*Мөрөн хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг манай газарт албан ёсоор хүлээлгэн өгөөгүй, энэ төлөвлөгөө нь магадлал хийлгээгүй тул мөрдөж ажиллах боломжгүй. Уг төлөвлөгөөнд тусгасан бүсчлэлийг харж тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулдаг*" гэсэн тайлбар өгсөн. Үүнийг **тодруулахад:**

"*Мөрөн хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг* холбогдох газруудад хүлээлгэж өгөөгүй /*Зурагнаас өөр материал байхгүй*/ ба гүйцэтгэгч "Инженер геодези" ХХК нь төлөвлөгөөнд магадлал хийлгэсний дараа хүлээлгэн өгөхөөр болсон ч энэ ажил удааширч, улмаар **2015 оны 8 дугаар сард магадлалаар баталгаажсан** байна.

Энэ байдлаас **харахад:** 2013-2015 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулахад Мөрөн хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг албан ёсоор мөрдөөгүй байгаа нь аймгийн ИТХ-ын тогтоолыг зөрчсөн, нөгөө талаар Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлын захиалагч[5] нь аймгийн ИТХ-аар магадлалаар баталгаажаагүй төлөвлөгөөг батлуулсан нь Хот байгуулалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6[6] дахь заалтыг зөрчсөн байна.

Магадлал хийгээгүй гэдэг үндэслэлээр 2013, 2014, 2015 онуудын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Мөрөн хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг мөрдлөг болгоогүй дараах төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна. Хүснэгтээр **харуулбал:**

*Мөрөн хотын хөгжлийн төлөвлөгөөг зөрчсөн*
*газар зохион байгуулалтын төлөвлөлт*

Хүснэгт 1:

| № | МХХЕТөлөвлөгөөнд тусгасан зориулалт | ТЖГЗБТ-нд тусгасан Зориулалт | Байршил, хаяг | Газрын хэмжээ /м2/ |
|---|---|---|---|---|
| **2013 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө[7]** | | | | |
| **1** | Нийтийн орон сууц | Бахархалын ордон | Баярын талбайн зүүн талд | 2000 |

[5] Хот байгуулалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5.2 "Аймаг, нийслэл, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлын захиалагч нь тухайн шатны Засаг дарга, хот, тосгоны захирагч"

[6] Хот байгуулалтын баримт бичгийн захиалагч нь хот байгуулалтын баримт бичигт холбогдох хууль тогтоомж, норм ба дүрэм, журамд заасны дагуу улсын экспертизийн дүгнэлт гаргуулна.

[7] Мөрөн сумын ИТХ-ын 2012 оны ээлжит 2 дугаар хуралдааны 10 дугаар тогтоол болон 2013 оны ээлжит 3 дугаар хуралдааны 17 дугаар тогтоолоор тус тус баталсан.

| | | | | |
|---|---|---|---|---|
| **2** | Барилга байгууламж төлөвлөөгүй | Авто граж | 8-р баг 3-р цэцэрлэгийн ар талд | 300 |
| **3** | Ногоон байгууламж | Автовокзал | 9-р баг Тайгын зам ХХК-ийн баруун талд | 20000 |
| **4** | Ногоон байгууламж | Аялал жуулчлал, худалдаа, үйлчилгээ | Хилэнт чиглэлийн замын баруун талд | 20000 |
| **2014 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө**[8] | | | | |
| **1** | Ногоон байгууламж | Худалдаа үйлчилгээ | Хилэнт чиглэлийн замын баруун талд | 5000 |
| **2** | Барилга байгууламж төлөвлөөгүй | Цэцэрлэг | 9-р баг Мөрөнжин цэцэрлэгийн зүүн талд | 3100 |
| **3** | Барилга байгууламж төлөвлөөгүй | Цэцэрлэг | 10-р баг 15-р гудамжны баруун талд | 1500 |
| **2015 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө**[9] | | | | |
| **1** | Барилга байгууламж төлөвлөөгүй | ШТС | Нисэх чиглэлийн зам дагуу НИК ШТС-ын зүүн талд | 3000 |
| **2** | Барилга байгууламж төлөвлөөгүй /зогсоол/ | Худалдаа, үйлчилгээ | ГХБХБГ-ын баруун урд талд | 300 |
| **3** | Барилга байгууламж төлөвлөөгүй /зогсоол/ | Кино театр | ГХБХБГ-ын зүүн талд | 3100 |
| **4** | Барилга байгууламж төлөвлөөгүй | Худалдаа, үйлчилгээ | Багш, хөгжлийн ордны зүүн талд | 400 |
| **5** | Ногоон байгууламж, нийтийн орон сууц | ШТС /хийн/ | УБ чиглэлийн замын хойд талд | 200 |
| **6** | Барилга байгууламж төлөвлөөгүй | Худалдаа, үйлчилгээ | 6-р багийн замын урд байрлах МТ ШТС-ын зүүн талд | 600 |
| **7** | Гал команд | ШТС | УБ чиглэлийн замын урд МТ ШТС-ын баруун талд | 3500 |
| **8** | Гал команд | ШТС /хийн/ | УБ чиглэлийн замын урд МТ ШТС-ын баруун талд | 4000 |
| **9** | Барилга байгууламж төлөвлөөгүй /зогсоол/ | Банк | Капитал банкны хойд талд | 80 |
| **10** | Кино театр, ногоон байгууламж | Агуулахын худалдаа | 12-р багийн 1-р гудамжны зүүн урд талд | 4000 |
| **11** | Барилга байгууламж төлөвлөөгүй | Үйлчилгээ | 18-р байрны баруун талд | 200 |

Хүснэгтийн 2014 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө хэсгийн 3-т тусгасан газрыг 2013 онд Мөрөн сумын Засаг даргын А-237 дугаар захирамжаар цэцэрлэгийн зориулалтаар олгосон /Захирамжид эзэмшигчийг тодорхой заагаагүй/ байна. Энэ нь Засаг даргын захирамжаар олгосон газарт дараа жил нь нөхөн төлөвлөлт хийснийг харуулж байна[10].

**Магадлалаар баталгаажсан** Мөрөн хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг авч үзэхэд: Холбогдох газруудад байсан зургаас өөрчлөлт ороогүй[11] баталгаажсан байна. Гэтэл уг төлөвлөгөө аль хэдий нь зөрчигдсөн байна. Энэ нь газар зохион байгуулалтын төлөвлөлт хариуцсан ажилтан болон хотын хөгжлийн ерөнхий

[8] Мөрөн сумын ИТХ-ын 2013 оны ээлжит 4 дүгээр хуралдааны 28 дугаар тогтоолоор баталсан.
[9] Мөрөн сумын ИТХ-ын 2014 оны ээлжит 9 дүгээр хуралдааны 56 дугаар тогтоол болон 2015 оны ээлжит 10 дугаар хуралдааны 62 дугаар тогтоолоор тус тус баталсан.
[10] Газрын тухай хуулийн 21.4.3-д “Энэ хуулийн 21.3.2-т заасанаас бусад газрыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу сумын хэмжээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг шийдвэрлэж, зохион байгуулах” гэсэн заалтыг зөрчсөн.
[11] Хүснэгт 1, хүснэгт 4-т харуулсан газрын тухайд

төлөвлөгөөг хуулийн дагуу шийдвэрлээгүй захиалагч нарын хариуцлагагүй үйл ажиллагаанаас болсон гэж үзэж байна.

Мөрөн хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний барилга, байгууламж төлөвлөөгүй газарт хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулан газар олголт хийх шаардлага гарч байгаа бөгөөд Хот байгуулалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.12-д *“Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө” гэж хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу тухайн дүүрэг, орон сууцны болон гэр хорооллын газар зохион байгуулалт, барилгажилт, тохижилтын төлөвлөлт, инженерийн шугам сүлжээний хангамжийг нарийвчлан тодотгож төлөвлөсөн хот байгуулалтын үйл ажиллагааны баримт бичиг”* гэж заасан ба холбогдох газрууд “Мөрөн сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө нь магадлалаар баталгаажаагүй, мөрдөх боломжгүй байсан” гэж тайлбарлан, хэзээ мөрдөж ажиллахаа шийдээгүй атлаа дараах хэсэгчилсэн төлөвлөгөөнүүдийг хийлгэж эхэлсэн байна. Хүснэгтээр үзүүлбэл:

*Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө*

Хүснэгт 2: /сая төгрөг/

| № | Хэсэгчилсэн төлөвлөгөөний нэр | Төлөвлөгөө хийлгэх шийдвэр /төсөв баталсан/ | Гүйцэтгэгч компани | Гэрээний дүн | Олгосон санхүүжилт | Тодруулга |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Шинэ Мөрөн хороолол | Мөрөн сумын ИТХ-ын 2012 оны ээлжит 2 дугаар хуралдааны 09-р тогтоол | Редсан ХХК | 232,6 | | |
| 2 | Мөрөн Түнэл сум | Аймгийн ИТХТ-ийн 2013.9.26-ны 56-р тогтоол | Эрхэт констаракшн ХХК | 118,5 | 71,1 | Уг зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг 2013.6.21-нд үнэлгээний хороо сонгон шалгаруулсан байна. Энэ нь төсөвт өртөг нь батлагдаагүй байхад ХАА-г зохион байгуулсныг харуулж байна. |
| 3 | Зүүн Мөрөн хороолол | Аймгийн ИТХ-ын 2014.12.04-ний ээлжит 10-р хуралдааны 02-р тогтоол | Инженер геодези ХХК | 39,7 | 10,0 | Уг зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг 2014.6.21-нд үнэлгээний хороо сонгон шалгаруулсан байна. Энэ нь төсөвт өртөг нь батлагдаагүй байхад ХАА-г зохион байгуулсныг харуулж байна. |

Эдгээр төлөвлөгөө нь өнөөгийн байдлаар эцэслэн батлагдаагүй байна.

*Газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах аргачлалын дагуу боловсруулсан байдал*:

Газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах аргачлалын 4-д тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулахад баримтлах зарчмыг тусгасан бөгөөд товч **дурдвал:**

- Аймаг, сумын нийгэм-эдийн засгийн салбаруудыг хөгжүүлэх хөтөлбөрүүд, Засаг даргын мөрийн хөтөлбөр, тухайн суманд хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдтэй уялдуулсан байх.
- Газар байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд чиглэгдсэн байх.

- Мянганы хөгжлийн зорилт, тогтвортой хөгжлийн үзэл баримтлал болон Монгол улсын соёрхон баталсан олон улсын конвенциуд, үндэсний хөтөлбөрүүдийн бодлого, үзэл баримтлал, зарчмуудтай нийцсэн байх зэргийг заасан ба Мөрөн сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тухайн суманд хэрэгжсэн дараах төсөл, хөтөлбөрүүд тусгагдаагүй байна. Хүснэгтээр харуулбал:[12]

Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалт

Хүснэгт 3: /сая төгрөг/

| № | Төсөл, арга хэмжээний нэр | Эх үүсвэр | Гүйцэтгэгч компани | Төсөвт өртөг |
|---|---|---|---|---|
| | 2013 он | | | |
| 1 | Багийн хөгжлийн төв | ОНХС | Эндус эрхэт ХХК | 180.0 |
| 2 | Халуун усны барилга | ОНХС | иргэн | 20.0 |
| | 2014 он | | | |
| 1 | Гүн өрмийн худаг /Чимэдийн толгой, Зүүн Мөрөн хороолол, гахай, тахианы хонхор/ | Улсын төсөв | Идэр чандмань ХХК | 74.0 |
| 2 | Авто зогсоол /Хүнсний зах орчмын тохижилт, зарим замын уулзвар/ | ОНХС | Дунз өргөө ХХК | 30.0 |
| 3 | Гүн өрмийн худаг /7, 13-р баг/ | ОНХС | Хөвсгөл Ундарга ХХК | 47.6 |

Мөрөн сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө зөвхөн ИТХ-аар баталсан тогтоол, түүний хавсралтаас өөр баримт бичиг байхгүй байгаа нь Газрын тухай хуулийн 25.4-д “Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газрыг эзэмшүүлэх, ашиглуулах, хамгаалах, нөхөн сэргээх, байршлыг тодорхойлсон жилдээ хэрэгжүүлэх зураг төслийн баримт бичиг байна” заалттай нийцэхгүй байна.

Мөн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах аргачлалын 6-д:

- Техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах, байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай арга хэмжээнүүдийн жагсаалтыг гаргах.
- Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах хүний нөөцийн чадавхийг бий болгох арга хэмжээнүүдийн жагсаалт гаргах
- Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв, хөрөнгийн эх үүсвэрүүдийг иргэн, ААНБ, иргэдийн бүлэг, нөхөрлөл, төсөл хөтөлбөрүүдийн санхүүжилт, сум, аймаг, улсын төсвийн санхүүжилт тус бүрээр нь тоймлож төлөвлөх зэргийг тусгасан ч Мөрөн сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө нь энэхүү шаардлагыг хангаагүй байна.

## 1.2 Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг зөрчин газар олгосон байна.

Газар олголтыг газар зохион байгуулалтын үндсэн баримт бичигтэй уялдуулж байгаа эсэхийг дараах байдлаар авч үзвэл:

[12] Аудитын хамрах хүрээ, цаг хугацаанаас хамаарч тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг Мөрөн суманд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнээс бусад хөтөлбөр, арга хэмжээтэй тулган шалгаагүй болно.

*Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу газар олгосон байдал:* Тайлангийн 1.1-д тусгасанчлан 2013 он, 2014 он, 2015 оны эхний хагас жилд олгосон газрыг Мөрөн хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зурагтай харьцуулахад дараах зөрчил илэрлээ. Хүснэгтээр харуулбал:

Мөрөн хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг зөрчин олгосон газар

Хүснэгт 4:

| № | Иргэн, ААНБ-ын нэр | Зориулалт | Төлөвлөгөөнд тусгасан зориулалт | Байршил, хаяг | Газрын хэмжээ /м2/ |
|---|---|---|---|---|---|
| **2013 он /Аймгийн Засаг даргын захирамжаар/** | | | | | |
| 1 | Мөрөн сумын ЗДТГ | Бахархалын ордон | Нийтийн орон сууц | Баярын талбайн зүүн талд | 2000 |
| 2 | Хөгжимт, драмын театр | ХДТ-ын барилга | Нийтийн орон сууц | Баярын талбайн зүүн хойд талд | 6400 |
| 3 | Хөгжимт, драмын театр | ХДТ-ын барилга | Ногоон байгууламж | Ирээдүй сургуулийн баруун хойд талд | 20000 |
| 4 | Авто тээврийн үндэсний төвийн Хөвсгөл аймаг дахь салбар | Автовокзал | Ногоон байгууламж | 9-р баг Тайгын зам ХХК-ийн баруун талд | 20000 |
| 5 | Мөрөн сумын ЗДТГ | 640 хүүхдийн сургууль | Барилга байгууламжийн төлөвлөлт хийгдээгүй | Бүрэнхаан бага сургуулийн урд | 10000 |
| 6 | Нэр бүхий 8 иргэнд | Гэр бүлийн хэрэгцээнд | Ногоон байгууламж | 13-р баг Хилэнт чиглэлийн замын баруун талд | 4000 |
| 7 | Ө.Төмөр<br>С.Бурмаа<br>Ц.Одонтуяа | Аялал, жуулчлал | Ногоон байгууламж | 13-р баг Хилэнт чиглэлийн замын баруун талд | 7500 |
| **2013 он /Мөрөн сумын Засаг даргын захирамжаар/** | | | | | |
| 1 | Улаан загалмайн хороо | Нийгмийн үйлчилгээ | Барилга байгууламжийн төлөвлөлт хийгдээгүй | 9-р баг 11-р цэцэрлэгийн баруун талд | 400 |
| 2 | /Хаана эзэмшүүлэхийг заагаагүй/ | Цэцэрлэг | Барилга байгууламжийн төлөвлөлт хийгдээгүй | 10-р баг 15-р гудамжны баруун талд | 1500 |
| **2014 он /Аймгийн Засаг даргын захирамжаар/** | | | | | |
| 1 | Хөвсгөл Центр ХХК | Авто зогсоол, ногоон байгууламж | Барилга байгууламжийн төлөвлөлт хийгдээгүй | 8-р баг | 360 |
| 2 | Г.Батцогт | Аж ахуйн | Үйлчилгээ, нийтийн орон сууц | 7-р баг УБ чиглэлийн замын урд МТ ШТС-ын зүүн талд | 6000 |
| **2014 он /Мөрөн сумын Засаг даргын захирамжаар/** | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1 | Хот тохижилт үйлчилгээний төв | Тоглоомын талбай | Ногоон байгууламж | 12-р баг 1-р гудамжны урд | 2700 |
| **2015 он /Мөрөн сумын Засаг даргын захирамжаар/** | | | | | |
| 1 | Нэмэн ХХК | ШТС | Барилга байгууламж төлөвлөөгүй | Нисэх чиглэлийн зам дагуу НИК ШТС-ын зүүн талд | 3000 |

Аудитын тайлан баталгаажуулахаас өмнө магадлалаар баталгаажсан Мөрөн хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө аймгийн ЗДТГ-ын ХБХ-т ирсэн бөгөөд уг төлөвлөгөөг хүснэгт 4–г бэлтгэхэд ашигласан зурагтай харьцуулахад өөрчлөлт ороогүй байсан болно.

Энэ нь Мөрөн хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хэдийнээ зөрчигдсөнийг харуулж байгаа бөгөөд Хот байгуулалтын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-д *“Хот, тосгоны ерөнхий төлөвлөгөөний үндсэн шаардлага, үе шатны зорилт, эдэлбэр газрын зориулалт, инженерийн шугам сүлжээний даац, технологийн горим зөрчиж газар олгохыг хориглоно”* гэсэн заалтыг зөрчиж байна.

Мөрөн хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй холбоотой гарсан зөрчилтэй холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцох саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлэхээр шийдвэрлэсэн болно.

*Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу газар олгосон байдал:* 2013 – 2015 онд шинээр олгосон газрыг тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй тулган шалгахад дараах зөрчил илэрлээ. Зөрчлийг он, оноор харуулбал:

### Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаагүй газарт олгосон газар

Хүснэгт 5:

| № | Иргэн, ААНБ-ын нэр | Зориулалт | Байршил, хаяг | Газрын хэмжээ /м2/ |
|---|---|---|---|---|
| **2013 он /Аймгийн Засаг даргын захирамжаар/** | | | | |
| 1 | Ч.Пүрэвдорж | Авто граж | 8-р баг 1-р хэсэг | 43 |
| 2 | У.Мэргэнжаргал | Гэр бүлийн хэрэгцээнд | 8-р баг | 500 |
| 3 | Хөгжимт, драмын театр | ХДТ-ын барилга | Баярын талбайн зүүн хойд талд | 6400 |
| 4 | Хөгжимт, драмын театр | ХДТ-ын барилга | Ирээдүй сургуулийн баруун хойд талд | 20000 |
| 5 | Мөрөн сумын ЗДТГ | 640 хүүхдийн сургууль | Бүрэнхаан бага сургуулийн урд | 10000 |
| 6 | Ө.Төмөр | Үйлдвэрлэл | Зам ангийн хойд талд | 5000 |
| 7 | Нэр бүхий 8 иргэнд | Гэр бүлийн хэрэгцээнд | 13-р баг Хилэнт чиглэлийн замын баруун талд | 4000 |
| **2013 он /Мөрөн сумын Засаг даргын захирамжаар/** | | | | |
| 1 | Улаан загалмайн хороо | Нийгмийн үйлчилгээ | 9-р баг 11-р цэцэрлэгийн баруун талд | 400 |
| 2 | Цагдаагийн газар | Авто дром | 1-р баг НИК ШТС-ын ард | 10000 |
| 3 | Мөрөн сумын ЗДТГ | Гүний худаг | 13-р баг 29-р худамжны зүүн талд | 25 |
| 4 | О.Баярмаа | Төмс, хүнсний ногоо | 13-р баг Чимэдийн толгойн ард | 10000 |
| 5 | /Хаана эзэмшүүлэхийг заагаагүй/ | Цэцэрлэг | 10-р баг 15-р гудамжны баруун талд | 1500 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 6 | Б.Наранжаргал | Гэр бүлийн хэрэгцээнд | 11-22-16 | 35 |
| **2014 он /Аймгийн Засаг даргын захирамжаар/** | | | | |
| 1 | О.Эрдэнэбат | Авто граж | 8-р баг 16-р байрны зүүн талд | 200 |
| 2 | Хөвсгөл Центр ХХК | Авто зогсоол, ногоон байгууламж | 8-р баг | 360 |
| 3 | Д.Мойлмаа | Гэр бүлийн хэрэгцээнд | 13-р баг | 450 |
| 4 | Б.Бат-Эрдэнэ | Ногоон байгууламж, авто зогсоол | 8-р баг Шинэ-Өгөөж ХҮТ-ийн ард | 480 |
| 5 | Г.Батцогт | Аж ахуйн | 7-р баг УБ чиглэлийн замын урд МТ ШТС-ын зүүн талд | 6000 |
| 6 | Төрийн орон сууцны корпораци | Нийтийн орон сууц | 13-р баг Цагаан-Уул хорооллын зүүн талд | 50000 |
| 7 | Хөвсгөл эрчим хүч ХХК | Дэд станц барих, шугам сүлжээ тавих | 7-р баг Мөрөн дэд станцаас зүүн тийш, үерийн усны далангийн зүүн талд | 10000[13] |
| 8 | Аяны жолоо ХХК | Цахилгаан дэд станц | 8-р баг ЭДЦС /бага сургууль/ -ийн урд | 20 |
| 9 | Мөрөн сумын ЗДТГ | Гүний худаг | 6-р баг НИК ХХК-ийн албан байрны ард | 24 |
| 10 | Мөрөн сумын ЗДТГ | Гүний худаг | 6-р баг БТСГ-ын ард | 24 |
| 11 | П.Намхайнямбуу | Гэр бүлийн хэрэгцээнд | 13-р баг | 500 |
| **2014 он /Мөрөн сумын Засаг даргын захирамжаар/** | | | | |
| 1 | Мөрөн сумын ЗДТГ | Аж ахуйн хашаа | 13-р баг РӨНС-ын баруун урд талд | 10000 |
| 2 | Мөрөн сумын ЗДТГ | Төмс, хүнсний ногоо | 13-р баг | 50000 |
| 3 | Мөрөн сумын ЗДТГ | Халуун ус | 10-р баг 15-р гудамжны баруун талд | 1500 |
| 4 | Хот тохижилт үйлчилгээний төв | Тоглоомын талбай | 12-р баг 1-р гудамжны урд[14] | 2700 |
| **2015 он /Аймгийн Засаг даргын захирамжаар/** | | | | |
| 1 | Г.Эрдэнэ | Авто граж | 8-р баг 18-р байрны зүүн талд | 24 |
| 2 | Б.Наранбаяр | Авто зогсоол, ногоон байгууламж | 13-р баг | 2104 |
| 3 | М.Мөнхбат | Гэр бүлийн хэрэгцээнд | 8-р баг 12-36 тоот | 277 |

Хүснэгтэд үзүүлсэн газар олголт нь Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4-*д* *"Аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд эзэмшүүлж болохоор зааснаас бусад газарт газар эзэмшүүлэхийг хориглоно"* гэсэн заалтыг зөрчсөн тул Газрын тухай хуулийн 63.1.12[15]-т заасны дагуу хариуцлага тооцох саналыг холбогдох байгууллагад хүргүүлэхээр шийдвэрлэсэн болно.

Хүснэгтээс **харахад:** 2014 онд Мөрөн сумын Засаг даргын захирамжаар олгосон хэсгийн 4 дэх газар нь Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3-д *"Энэ*

[13] Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Төсөвт байгууллагын хэрэгцээнд нийт 5000 м2 газар олгохоор төлөвлөсөн.
[14] Аймгийн ИТХ-ын 2010 оны ээлжит 7 дугаар хуралдааны 03 дугаар тогтоолоор баталсан инженерийн шугам, сүлжээ бүхий газарт тус газар орсон болно.
[15] Энэ хуулийн 33.4-д заасан журмыг зөрчсөн албан тушаалтныг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг дөрвөөс арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, гаргасан шийдвэрийг нь хүчингүй болгон, хохирлыг нөхөн төлүүлэх

*хуулийн 21.3.2*[16]*-т заасанаас бусад газрыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу сумын хэмжээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг шийдвэрлэж, зохион байгуулах*" гэсэн заалтыг зөрчсөн байна.

## 1.3 Газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт явуулахгүйгээр газар олгосоор байна.

Мөрөн сумын ИТХ-ын хуралдааны тогтоол, шийдвэрээр батлагдсан "Газар зохион байгуулалтын 2013, 2014 он, 2015 оны эхний хагас жил"-ийн төлөвлөгөөнд үндэслэн Засгийн газрын 2003 оны 28-р тогтоолоор баталсан "Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам"-ын дагуу иргэн, аж ахуйн нэгж байгууллагад дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтаар 25 нэгж талбарт 121,9 мянган $м^2$ газар эзэмшүүлсэн байна.

Аймгийн ГХБХБГ нь газар эзэмшүүлэх дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтаар 2013 онд 9 нэгж талбарт дуудлага худалдааг 2 удаа зохион байгуулан ялагч иргэн, аж ахуй нэгж байгууллагад аймгийн Засаг даргын захирамжаар нийт 37,5 мянган $м^2$ газар эзэмшүүлжээ.

Иргэн, аж ахуй нэгж байгууллагад журмын дагуу дуудлага худалдаа төсөл сонгон шалгаруулалтаар газар олгож байгаа хэдий ч 2013 он, 2014 он, 2015 оны жил жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй газарт дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт явуулахгүйгээр Аймгийн Засаг даргын захирамж гарган иргэдэд газар эзэмшүүлсэн нь Газрын тухай хуулийн 33.1.2[17] дахь заалтыг зөрчсөн байна. /Хүснэгт 8:/

Олгогдсон газрын мэдээллийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 6:

| № | Үзүүлэлт | Дуудлага худалдаагаар эзэмшүүлсэн газар | | | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| | | 2013 он | 2014 он | 2015 он | |
| 1 | Мөрөн сум | 8 | 6 | 2 | 16 |
| 2 | ГХБХБГ | 9 | 0 | 0 | 9 |
| | **Нийт дүн** | | | | **25** |

Иргэн, аж ахуй нэгж байгууллагад эзэмшүүлсэн нийт 39 газраас **35,8** хувь буюу **14** газрыг дуудлага худалдаа, төсөл сонгон шалгарууулалт явуулахгүйгээр эзэмшүүлсэн байна. Дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтгүйгээр эзэмшүүлсэн 14 газрыг аргачлалын дагуу тооцвол дуудах доод үнэ буюу наад зах нь 13,97 сая төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлэх боломж алдагдсан байна.

Мөрөн сумаас зохион байгуулсан 2015 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн дуудлага худалдаагаар Мөрөн сумын багш хөгжлийн ордны зүүн талд байрлах худалдаа үйлчилгээний зориулалт бүхий 400 м2 газарт 3 сая төгрөгийн дээд үнэтэйгээр иргэн И.Батбаатарыг шалгаруулсан нь Газрын тухай хуулийн 21.4.3[18]

[16] Аймгийн Засаг даргын бүрэн эрх: "Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний дагуу аймгийн төвийн инженерийн шугам, сүлжээ бүхий газруудад газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг шийдвэрлэнэ. Уг асуудлыг шийдвэрлэхэд тухайн сумын Засаг даргын саналыг авсан байна".

[17] Энэ хуулийн 33.1.1-д заасанаас бусад зориулалтаар болон энэ хуулийн 29.1, 29.2, 29.3-т заасан хэмжээнээс илүү газар эзэмших хүсэлт гаргасан иргэн, аж ахуй нэгж байгууллагад газар эзэмшүүлэх асуудлыг тухайн шатны Засаг дарга дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулах зарчмаар шийдвэрлэнэ. Төсөл шалгаруулах, дуудлага худалдаа явуулах журмыг Засгийн газар тогтооно.

[18] Энэ хуулийн 21.3.2 –т заасанаас бусад газрыг сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурлаас баталсан тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу сумын хэмжээнд иргэн, аж ахуй нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг шийдвэрлэж, зохион байгуулах

дахь заалтыг зөрчсөн, Мөрөн сумын Засаг дарга Ц.Гансүх Газрын тухай хуулийн 21.4[19]-т заасан бүрэн эрхээ хэтрүүлэн, мөн хуулийн 21.3-т заасан Аймгийн засаг дарга газрын харилцааны талаархи бүрэн эрхийн хүрээнд дуудлага худалдааг зохион байгуулсан байна. Иймээс уг дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтыг хүчингүй болгож Аймгийн засаг даргын газрын харилцааны талаархи бүрэн эрхийн хүрээнд дуудлага худалдааг дахин зохион байгуулах шаардлагатай гэж ***албан шаардлага*** хүргүүлж байна.

Дуудлага худалдаанд оролцож буй иргэд, аж ахуй нэгж нь тухайн сонирхсон нэгж талбартаа хэт өндөр үнэ санал болгож, улмаар дуудлага худалдаа явуулах журманд заасан хугацаанд төлбөрөө төлж чадахгүй байгаагаас үүдэн дуудлага худалдаа удаа дараа хүчингүй болж байна.

Мөрөн сумын Засаг даргын захирамжаар олгож буй газар эзэмшүүлэх дуудлага худалдааны ялагчдын хувийн хэрэгт дараах баримтын бүрдэл дутуу байна. Үүнд :

- ✓ Нэгж талбарыг харуулсан тойм зураг
- ✓ Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулахаар шийдвэрлэсэн зураг, нэгж талбарын эргэлтийн цэгүүдийг иргэн, хуулийн этгээдэд хүлээлгэн өгсөн акт, бусад нотлох баримт бичиг
- ✓ Кадастрын зураг
- ✓ Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны паспорт
- ✓ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний материал

Мөрөн сумаас үйлдвэрлэл үйлчилгээний зориулалт бүхий газрыг дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтаар олгохдоо Газрын тухай хуулийн 34.2[20], 34.7[21] дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна. Тухайлбал: Мөрөн сумын 13-р баг Радио өргөн нэвтрүүлэх станцын зүүн талд байрлах үйлдвэрлэл үйлчилгээний зориулалт бүхий 6 нэгж талбарын нийт 40 мянган м2 газар.

Иргэн аж ахуй нэгж, байгууллагын эзэмшиж буй газрын гэрээ, гэрчилгээг шинэчлэхдээ дуудлага худалдаа төсөл сонгон шалгаруулалт явуулахгүйгээр **хэмжээг нэмэгдүүлж** шууд захирамж гарган олгосон байна. /Хүснэгт 8/

Энэ талаар ГХБХБГ-ын холбогдох мэргэжилтнүүдээс тодруулахад хэмжээсийн алдаа зөрүүтэй байсан гэх боловч зарим нэгж талбарын хэмжээ өмнөх хэмжээсийн алдаа бус, харин нэгж талбарын хэмжээг санаатайгаар нэмэгдүүлсэн нь аудитаар тогтоогдсон. /Хүснэгт 8-аас харна уу/.

2013 онд аймгийн ГХБХБГ-т зохион байгуулагдсан дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын хувьд дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтад оролцож байгаа иргэн, аж ахуйн нэгжийн дэнчингийн мөнгө болох 1,5 сая төгрөг, оролцогчийн төлбөр болох 3,6 сая төгрөгийг бэлнээр хураан авсан байна. Мөнгийг хураагж авахдаа ГХБХБГ-ын жолооч, нярав Д.Сумьяабазараар хураалгасан бөгөөд зарцуулалтад хэн ч хяналт тавиагүй, зарцуулсан анхан шатны баримтын бүрдэл дутуу зэрэг зөрчил илэрлээ.

Газрын дуудлага худалдааг зохион байгуулах комиссыг томилох тухайн шатны Засаг даргын захирамжинд дуудлага худалдааны төлбөр тооцоо,

[19] Сумын засаг дарга газрын харилцааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
[20] Үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах зориулалтаар газар эзэмших эрх авсан иргэн, аж ахуй нэгж, байгууллага нь 90 хоногт багтаан байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хийсний дараа тэдгээртэй газар эзэмших гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгон улсын бүртгэлд бүртгэнэ.
[21] Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зориулалтаар эзэмшилд олгож байгаа газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа болон байгаль орчны нөлөөллийн үнэлгээг тухайн газар эзэмших гэрээний хавсралт болгоно.

зарцуулалт, тайлагналт зэрэгтэй холбоотой асуудлыг тодорхой тусгаагүй, хяналтгүй байна.

### 1.4 Төрийн байгууллагын зайлшгүй хэрэгцээнд эзэмшүүлсэн газрын эзэмших, ашиглах эрхийг холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэрээр бусдад шилжүүлээгүй байна.

**А. Дуудлага худалдаа, төсөл шалгаруулалтаар эзэмшүүлэхээр хуульд заасан журмыг зөрчиж газар эзэмшүүлсэн байна.**

Мөрөн сумын Засаг дарга Мөрөн сумын инженерийн шугам сүлжээтэй бүсийн гадна, аймгийн Засаг дарга инженерийн шугам сүлжээтэй бүсэд дараах байдлаар шинээр газар эзэмших эрх олгосон байна. *Үүнийг хүснэгтээр харуулбал:*

Хүснэгт 7:

| № | Засаг дарга | 2013 он | | 2014 он | | 2015 эхний хагас жилд | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Захирамжийн тоо | Газрын хэмжээ /га/ | Захирамжийн тоо | Газрын хэмжээ /га/ | Захирамжийн тоо | Газрын хэмжээ /га/ |
| 1 | Мөрөн сумын Засаг дарга | 15 | 23,4 | 13 | 28,5 | 5 | 1,9 |
| 2 | Аймгийн Засаг дарга | 11 | 16,9 | 9 | 7,2 | 5 | 1,1 |

Газрын тухай хуульд зааснаар газар эзэмших эрхийн гэрчилгээ нь гэр бүлийн хамтын хэрэгцээний, төрийн байгууллагын, аж ахуйн нэгж байгууллагын гэсэн 3 төрөлтэй байна.

Газрын тухай хуульд зааснаар:

1. *Мөрөн сумын /аймгийн төвийн/ инженерийн шугам сүлжээ бүхий бүсэд аймгийн Засаг дарга газар эзэмших эрх үүсгэх*[22]*,*
2. *Мөрөн сумын /аймгийн төвийн/ инженерийн шугам сүлжээ бүхий бүсээс гаднах газарт Мөрөн сумын Засаг дарга захирамж гаргаж эзэмших эрх үүсгэж байна.*

Аймгийн ИТХ-ийн 2004 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн 35 тоот тогтоолоор анх “Мөрөн сумын инженерийн шугам сүлжээ бүхий газрын бүсчлэл”-ийг тогоосон бөгөөд мөн хурлын 2010.10.20-ны өдрийн 3 дугаартай “Мөрөн сумын инженерийн шугам сүлжээ бүхий газрын хилийн цэсийг өргөтгөх тухай” тогтоолоор өргөтгөн баталсан байдаг.

Аймгийн Засаг дарга Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 29.5, 29.6 дахь заалтуудыг зөрчиж иргэнд анх эзэмшүүлсэн газрын хэмжээг нэмэгдүүлж, шинээр газар эзэмшүүлэхдээ дуудлага худалдаа, төсөл шалгаруулалт явуулалгүй дараах газрыг олгосон байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

*Дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтгүйгээр олгосон газар*

Хүснэгт 8:

| № | Захирамж огноо | Иргэн, ААН нэрс | Газрын зориулалт | Газрын байршил | Өмнөх хэмжээ | Хэмжээ | Газрын зөрүү | Хүчингүй болгож буй захирамж дугаар | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|

[22] 21.3.2. аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний дагуу аймгийн төвийн инженерийн шугам, сүлжээ бүхий газруудад газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг шийдвэрлэнэ. Уг асуудлыг шийдвэрлэхэд тухайн сумын Засаг даргын саналыг авсан байна.

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **1** | 2013. 07.28 А/18 8 | П.Эрдэнэ-Уул | Техник зах | 7-р баг 33-9 тоот | 10888 | 15215 | 4327 | Мөрөн сум ЗД-ын 2003.05.30 60-р | Гэрээ, гэрчилгээ шинэчлэхдээ талбайн хэмжээг шийдвэргүйгээр нэмэгдүүлсэн байна. |
| **2** | 2013. 07.28 А/18 8 | Ц.Цэрэнб ат | Түүхий эдийн зах | 7-р баг | 13600 | 14841 | 1241 | Мөрөн сум ЗД-ын 2003.05.30 60-р | Гэрээ, гэрчилгээ шинэчлэхдээ талбайн хэмжээг шийдвэргүйгээр нэмэгдүүлсэн байна. |
| **3** | 2013. 09.23 А/22 9 | Ч.Пүрэвд орж | Авто граж | 8-р баг 1-р хэсэг | 0 | 43 | 43 | Шинээр | Дуудлага худалаа явуулахгүйгээр олгосон байна. |
| **4** | 2014. 07.09 А/27 8 | О.Эрдэнэ бат | Авто граж | 8-р баг 16-р байр зүүн | 0 | 200 | 200 | Шинээр | Дуудлага худалаа явуулахгүйгээр олгосон байна. |
| **5** | 2014. 08.15 А/31 7 | Л.Уранцэ цэг | Өлөнгий н цех | 13-р баг | 0 | 700 | 700 | Шинээр | Дуудлага худалаа явуулахгүйгээр олгосон байна. |
| **6** | 2014. 11.18 А/41 9 | П.Сандагс үрэн | Үйлдвэр лэл | 9-р баг үерт 7 тоот | 1750 | 4534 | 2784 | Мөрөн сум ЗД-ын 2010.08.30 124-р захирамж | Гэрээ, гэрчилгээ шинэчлэхдээ талбайн хэмжээг шийдвэргүйгээр нэмэгдүүлсэн байна. |
| **7** | 2014. 12.30 А/46 8 | Б.Бат-Эрдэнэ | Авто зогсоол | 8-р баг Шинэ өгөөж | 0 | 480 | 480 | Шинээр | Дуудлага худалаа явуулахгүйгээр олгосон байна. |
| **8** | 2014. 07.09 А/27 8 | “Хөвсгөл центр” ХХК | Авто зогсоол | 8-р баг | 0 | 500 | 500 | Шинээр | Дуудлага худалаа явуулахгүйгээр олгосон байна. |
| **9** | 2014. 12.30 А/46 8 | Г.Батцогт | Аж ахуйн | 7-р баг МТ-ийн зүүн | 0 | 6000 | 6000 | Шинээр | Дуудлага худалаа явуулахгүйгээр олгосон байна. |
| **10** | 2015. 05.07 А/16 7 | Мондэвш ХХК | Зоорь | 13-р баг бойн ард | 1000 | 2879,8 | 1879,8 | АЗД-ын 2012.10.25 А/299 | Гэрээ, гэрчилгээ шинэчлэхдээ талбайн хэмжээг шийдвэргүйгээр нэмэгдүүлсэн байна. |
| **11** | 2015. 05.07 А/16 7 | Ц.Нямгэр эл | Худалда а үйлчилгэ э | 2-р байрны ард | 18 | 86 | 68 | АЗД-ын 2012.04.17 А/299 | Гэрээ, гэрчилгээ шинэчлэхдээ талбайн хэмжээг шийдвэргүйгээр нэмэгдүүлсэн байна. |
| **12** | 2015. 05.07 А/16 7 | Б.Наранб аяр | Авто зогсоол | 13-р баг | 0 | 2104 | 2104 | Шинээр | Дуудлага худалаа явуулахгүйгээр олгосон байна. |
| **13** | 2013. 12.26 А/31 7 | А.Ганзори г | Худалда а үйлчилгэ э | 13-р баг Бой | 0 | 1529 | 1529 | Шинээр | Дуудлага худалаа явуулахгүйгээр олгосон байна. |
| | | | | | | | 25041, 8 | | |

Дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтгүйгээр захирамж гаргаж эзэмшүүлсэн дээрх газруудын эзэмших эрхийг хүчингүй болгож чөлөөлөгдсөн

газрыг төлөвлөгөөнд тусгуулан дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулах замаар эзэмшүүлэхээр ***албан шаардлага*** хүргүүлэхээр шийдвэрлэв.

Мөрөн сумын Засаг даргын хувьд Мөрөн сумын инженерийн шугам сүлжээ бүхий бүсээс гаднах нутаг дэвсгэрт газар эзэмшүүлэхдээ хуульд заасан дуудлага худалдаа явуулах, төсөл шалгаруулах ажлыг зохион байгуулж ялагчид газрыг эзэмшүүлсэн байна.

**Б. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд эзэмшүүлж болохоор заасанаас бусад газарт газар эзэмшүүлэхийг хориглосон заалтыг зөрчсөн байна.**

Газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 29.2, 29.3- т заасан болон төсөвт байгууллагад зайлшгүй хэрэгцээтэй газрыг эзэмшүүлэх тухай шийдвэрийг аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан газар зохион байгуулалтын ерөнхий болон тухайн жилийн төлөвлөгөөний дагуу тухайн шатны Засаг дарга гаргахаар[23] хуульчлагдсан.

Засаг дарга дээрх эрх хэмжээг хэрэгжүүлэхдээ Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4-д заасан “Аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд эзэмшүүлж болохоор заасанаас бусад газарт газар эзэмшүүлэхийг хориглоно” гэснийг зөрчиж газар эзэмшүүлсэн байна.

**В. Төрийн байгууллагын зайлшгүй хэрэгцээнд эзэмшүүлсэн газрын эзэмших, ашиглах эрхийг холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэрээр бусдад шилжүүлээгүй байна.**

***Нэгдсэн эмнэлгийн газрын тухайд авч үзвэл:***

Аймгийн Нэгдсэн эмнэлэгт Мөрөн сумын Засаг даргын 1999 оны 3 сарын 31-ний өдрийн 18 тоот захирамжаар 41966 м2 газрыг контор, эмнэлгийн үйлчилгээний зориулалтаар эзэмшүүлсэн. Ийнхүү эзэмшүүлсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан “төрийн өөрийн өмч”-ийг үүсгэсэн байна.

2015 оны байдлаар Нэгдсэн эмнэлгийн эзэмшлийн газраас дараах аж ахуйн нэгжүүдэд газар эзэмшүүлсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

| № | Газар эзэмшигчийн нэр | Анх газар эзэмших эрх олгосон | | Инженерийн шугам сүлжээтэй бүсэд шилжсэнтэй холбоотойгоор шинэчилсэн | | Газрын эрхтэй холбоотойгоор ИТХ-ын шийдвэр гарсан эсэх |
|---|---|---|---|---|---|---|
| | | Албан тушаалтан | Огноо, дугаар | Албан тушаалтан | Огноо, дугаар, газрын хэмжээ | |
| 1 | Хөвсгөл Тана ХХК | Мөрөн сумын Засаг дарга | 1999.03.27/ 18 /засвартай/ | Аймгийн Засаг дарга | 2010.09.23/А-349/604,9 м2 | Үгүй |
| 2 | Улаанзагалмайн хороо | Байхгүй | Байхгүй | Аймгийн Засаг дарга | 2012.11.23/А-330/1302,7м2 | Үгүй |

[23] Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх хэсэгт

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3 | Жаргалан эмнэлэг | Газрын харилцаа барилга хот байгууллалтын газарт хувийн хэрэг байхгүй | | | | |
| 4 | Р.Нарантуяа | Аймгийн Засаг дарга | 2013.6.28/А -161 | | | Үгүй |
| 5 | Ч.Болдбаатар | Аймгийн Засаг дарга | 2012.11.09/ А-31 | | | Үгүй |

Жич: Р.Нарантуяагийн эзэмшлийн, одоо Оюу ундраа эмнэлэг үйл ажиллагаа явуулж байгаа газрын тухайд Аймгийн Улаанзагалмайн нийгэмлэг өөрийн эзэмшлийн гэх 300 м2 газартай Цайны газрын барилгыг Бэствайт ХХК-д худалдсан бөгөөд Вэствайт ХХК-иас Р.Нарантуяагийн эзэмшилд хэлцлийн журмаар аймгийн засаг даргын 2013.6.28-ны өдрийн А-161 тоот захирамжаар шилжсэн байна.

Улаан загалмайн хороонд анх газар эзэмшүүлсэн гэх Мөрөн сумын Засаг даргын 1997 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 21 тоот захирамж аймгийн архивт байхгүй, тухайн онд хамаарах захирамж нь өөр дугаартай, өөр харилцааг зохицуулсан захирамж байгаагаас харахад анхнаасаа тус байгууллагад газар эзэмших эрх үүсээгүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 2/3-т заасан “Орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийг хувьчлах ба бусдад шилжүүлэх, шинээр олж авах жагсаалт, төлөвлөгөө, эх үүсвэрийг хэлэлцэж батлах” нь орон нутгийн ИТХ-ын бүрэн эрхэд хамаарах бөгөөд ийнхүү шийдвэр гараагүй байхад Засаг дарга төрийн өөрийн өмч болох “газар”-ыг бусдад эзэмшүүлсэн нь хууль зөрчсөн байна.

Аймгийн Засаг даргын 2012.5.21-ний өдрийн А/158 тоот захирамжаар Нэгдсэн эмнэлгийн газар эзэмших эрхийн гэрээ, гэрчилгээ шинэчлэгдэж, нийт талбай нь 38,371 м2 болох нь баталгаажсан байна.

***ЭМГ-ын хашаанд баригдаж байгаа орон сууцны тухайд:***

Аймгийн Эрүүл мэндийн газрын захиалгаар Хөвсгөл Геологи ХК нийт 2321 м2 талбайтай 5 давхар 40 айлын орон сууцны барилгын ажлыг “Барилгын ажил гүйцэтгэх гэрээ”-ний үндсэн дээр түлхүүр гардуулах нөхцлөөр гүйцэтгэж байна. Орон сууцны барилга барихтай холбоотойгоор гүйцэтгэгч компанид газрын эрх шилжээгүй байна. Цаашид тухайн орон сууцны барилгын газар эзэмших эрхтэй холбоотой асуудлыг аймгийн ИТХ-д тавьж Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан журамд нийцүүлэн шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

**Г. “Гэр бүлийн хэрэгцээний” зориулалтаар иргэнд газар эзэмшүүлж байгаа байдлын талаар:**

Аймгийн Засаг даргын шийдвэрээр Мөрөн сумын инженерийн шугам сүлжээтэй бүсэд иргэнд гэр бүлийн хэрэгцээнд нь зориулан газар эзэмшүүлж байгаа байдал нээлттэй, ил тод биш байна.

***Тухайлбал:*** Аймгийн Засаг даргын 2012 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/334 тоот захирамжаар аймгийн төвийн инженерийн шугам сүлжээтэй бүсэд хамаарах газарт нэр бүхий 30 иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар эзэмшүүлсэн байна. Энэхүү газрыг иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар эзэмшүүлэхээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан газар зохион

байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдаагүй байна[24]. Уг газарт инженерийн шугам сүлжээний ажил 2012 онд орон нутгийн хөрөнгө оруулалт болох 277,0 сая төгрөгөөр хийгдсэн. Түүнчлэн энэ газраас иргэдэд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар эзэмшүүлэх үйл явц нийтийн дунд нээлттэй явагдаагүй байна. Энэ нь Газрын тухай хуульд заасан “газар өмчлөх, эзэмших, ашиглахад шударга ёс, тэгш байдлыг хангах[25]” зарчимд нийцэхгүй байна.

Тус газар нь газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд иргэдэд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар эзэмшүүлэхээр тусгагдаагүйн дээр иргэдэд газар эзэмшүүлэх тухай захирамжид газрын хэмжээг заагаагүй зэрэг нь захиргааны актын илт хууль бус шинжийг илэрхийлж байна. Иймд холбогдох албан тушаалтануудад **албан шаардлага** хүргүүлж байна.

*Аймгийн Засаг даргын 2012 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/334 тоот захирамжийг хавсралт 4-өөс харна уу*

## Бүлэг 2

**ГАЗАР ЭЗЭМШИЖ, АШИГЛАЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГУУД 2013-2014 ОНУУДАД 48,0 САЯ ТӨГРӨГИЙН ГАЗРЫН ТӨЛБӨРӨӨ ТӨЛӨӨГҮЙ БАЙНА.**

### 2.1 Иргэнд газар өмчлүүлэх ажил хуульд заасан журмын дагуу явагдаж байгаа боловч төрийн байгууллагын зүгээс иргэнд “газар өмчлүүлэх ажил”-ыг идэвхижүүлэх шаардлагатай байна.

Хөвсгөл аймаг 10062882 га нутаг дэсгэртэй, 31,0 мянган өрхтэй, 124.7 мянган хүнтэй. Хот суурингийн 18583.7 га газартай энэ нь нийт нутаг дэсгэрийн 0.18 %-ийг эзэлдэг. Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлэх газрын хэмжээг тогтоохдоо хуульд заасан дээд хэмжээгээр гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлэх боломжгүй байсан тул аймгийн хүн ам, өрхийн тоо, хот суурингийн газрын нөөцөөс хамаарч өрхийн эзэмшиж байгаа хашааны газрыг нь өмчлүүлэхээр аймгийн ИТХ-аар шийдвэрлэсэн тухай дурьдсан байна.

**Мөрөн сумын иргэдэд газар өмчлүүлсэн байдлын талаар:**

МУ-ын иргэнд газар өмчлөх тухай хуульд зааснаар газар өмчлөх эрхээ баталгаажуулсан[26] байдлыг он, оноор харуулбал:

Хүснэгт 9:

| № | Он | Төлөвлөсөн | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **2013** | МУ-ын ЗГ-ын 2013 оны 179 дүгээр тогтоолоор Хөвсгөл аймагт нийт 325.0 га газрыг иргэнд өмлүүлэхээр | Тус онд аймгийн хэмжээнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 24,7 га газрыг иргэдэд өмчлүүлэх шийдвэрийг |

[24] Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь хэсэгт “ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний дагуу аймгийн төвийн инженерийн шугам, сүлжээ бүхий газруудад газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг шийдвэрлэнэ. ”
[25] Газрын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь хэсэг
[26] 22.1-д Иргэнд газар өмчлүүлэх эрх бүхий Засаг даргын гаргасан шийдвэрийг үндэслэн иргэнд өмчлүүлсэн газрыг үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хууль тогтоомжид заасны дагуу улсын бүртгэлд бүртгэж тухайн иргэн уг газрын хууль ёсны өмчлөгч мөн болохыг баталгаажуулсан Үл хөдлөх хөрөнгийн улсын бүртгэлийн гэрчилгээ /цаашид “Улсын бүртгэлийн гэрчилгээ” гэх/-г үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн байгууллагаас олгоно.”
25.1-д “Иргэнд өмчлүүлсэн газрыг энэ хуулийн 22.1-д заасны дагуу бүртгэснээр тухайн иргэний газар өмчлөх эрх үүснэ”

| | | | |
|---|---|---|---|
| | | шийдвэрлэсэн. Үүнээс гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнэгүй өмчлүүлэхээр 323.83 га, газар тариалангийнхаас бусад аж ахуйн зориулалтаар 1.80 га газрыг тус тус иргэнд өмчлүүлэхээр төлөвлөсөн. | аймгийн Засаг дарга гаргасан байна. Тус онд Мөрөн сумын иргэд 19,5 га газрыг өмчлөх эрхийг улсын бүртгэлд бүртгүүлж баталгаажуулсан байна. Энэ нь ЗГ-ын тогтоолд заасан иргэнд өмчлүүлэхээр заасан хэмжээний 6 хувийг эзэлж байна. Газар тариалангийнхаас бусад аж ахуйн зориулалтаар иргэн газар өмчлөөгүй байна. |
| 2 | **2014** | МУ-ын ЗГ-ын 2014 оны 179 дүгээр тогтоолоор Хөвсгөл аймагт нийт 291.81 га газрыг иргэнд өмлүүлэхээр шийдвэрлэсэн. Үүнээс гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнэгүй өмчлүүлэхээр 277.2 га, төмс хүнсний ногооны чиглэлээр 14.0 га, газар тариалангийнхаас бусад аж ахуйн зориулалтаар 0.61 га газрыг тус тус иргэнд өмчлүүлэхээр төлөвлөсөн байна. | Тус онд аймгийн хэмжээнд 12 га газрыг иргэдэд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлэхээр аймгийн Засаг даргын захирамж гарсан байна. Мөрөн сумын иргэд 17,2 га газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмлөх эрхээ улсын бүртгэлд бүртгүүлж баталгаажуулсан байна. Үүнийг ЗГ-ын тогтоолоор батлагдсан иргэнд өмчлүүлэх газрын хэмжээнд харьцуулбал 6,2 хувийг эзэлж байна. |
| 3 | **2015/2** | Аймгийн Засаг даргын захирамжаар 1,8 га газарт гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар иргэнд газар өмчлүүлэх шийдвэр гаргасан. | Тухайн оны эхний хагас жилийн байдлаар Мөрөн сумын нутаг дэвсгэрт хамаарах 4,6 га газарт иргэн гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар өмчлөх эрхээ улсын бүртгэлд бүртгүүлж баталгаажуулсан байна. |

Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлсэн газрын хэмжээ нь хуульд заасан хэмжээ хязгаарын дотор багтаж байна.

Газар өмчлөх эрх үүсгэсэн газрын байршлууд нь тухай жилд иргэдэд өмчлүүлэхээр батлагдсан Мөрөн сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан байна.

**Аймгийн ГХБХБГ-ын 2014 оны ажлын бичмэл тайланд:** *"Мөрөн сумын хувьд аймгийн төвийн сум бөгөөд 2014 онд тус сумын төвд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 800 иргэнд 48 га газрыг үнэгүй өмчлүүлэхээр одоо эзэмшиж байгаа газрын нийт хэмжээгээр нь тогтоосон. Уг төлөвлөгөөнд гэр бүлийн хэрэгцээнийхээс бусад зориулалтаар газар өмчлүүлэхээр тусгаагүй. Төлөвлөгөөний дагуу 12.04 га газрыг эзэмшиж байгаа хашааных нь хэмжээгээр 183 иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнэгүй өмчлүүлсэн"* гэж дурдсан байна.

Газар өмчлүүлэх үйл явц нь МУ-ын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд зааснаар "газар өмчлүүлэх арга хэмжээг газар өмчлөн авахыг хүссэн иргэний сайн дурын үндсэн дээр зөвхөн энэ хуульд заасан зориулалтаар төр олон нийтийн хяналтын дор ил тод явуулах",[27] "Газрын тухай хуулийн дагуу иргэний эзэмшсэн газар нь энэ хуулийн 5.1.2-т заасан төлөвлөгөөнд тусгагдсан иргэдэд өмчлүүлэх газарт хамаарч байгаа бөгөөд тухайн иргэн хүсэлт гаргасан тохиолдолд уг газрыг түүнд өмчлүүлэх"[28] гэж заасан агуулгаас харахад албадлагын шинжтэй бус газар эзэмшигч иргэний хүсэл зоригоос ихээхэн хамаарч байна. Энэ нь МУ-ын ЗГ-ын газраас баталсан иргэнд газар өмчлүүлэх төлөвлөгөөг биелүүлэхэд бэрхшээл учруулж байна. Иймд хууль, журмын зорилгыг хангахад зөрчил үүсгэж байгаа асуудлын талаар холбогдох дээд шатны байгууллагаараа дамжуулан хууль

[27] МУ-ын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 5.1.1 дэх хэсэгт
[28] МУ-ын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5.1 дэх хэсэгт

тогтоогч, журам тогтоогчид мэдээлэл, санал хүргүүлж ажиллах шаардлагатай байна.

Иргэнд газрыг өмчлүүлэх, газрын өмчлөх эрхийн үр ашгийг иргэдэд сурталчлах ажлын хүрээнд Мөрөн сум 2013 он, 2015 оны эхний хагас жилд иргэнд газар өмчлүүлэх аяныг зохион байгуулсан бол, 2014 онд иргэнд газар өмчлүүлэх аян, бусад үйл ажиллагааг зохион байгуулаагүй бөгөөд газар өмчлүүлэх аян зохион байгуулсан жил буюу 2013 онд иргэнд газар өмлүүлэхтэй холбогдуулан гаргасан шийдвэр хамгийн их хэмжээг буюу 24,7 га-г, газар өмчлөх эрхээ улсын бүртгэлд бүртгүүлж баталгаажуулсан 19,5 га газрыг хамарсан байдлаас иргэний газар өмчлөх явцад төрийн байгууллагын идэвхижүүлэлт, мэдээлэл ач тусаа өгдөг нь харагдаж байна.

Иргэнд өмчлүүлэх газрыг МУ-ын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 6 дугаар зүйлээр тодорхойлсон[29] бөгөөд Мөрөн сумын нутаг дэвсгэрт газар өмчлүүлэхдээ энэ хуулиар тодорхойлсон иргэнд өмчлүүлэх газарт газар өмчлүүлсэн байна.

## 2.2 Газрыг зориулалтын дагуу ашиглахгүй байна.

Аудитын явцад иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд газраа гэрээнд тусгагдсан хугацаанд зориулалтын дагуу үр дүнтэй эзэмшиж, ашиглаж байгаа эсэхийг шалгахад: 2013-2015 онуудад дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтаар олгогдсон **25** газраас **13** газар нь гэрээнд заагдсан хугацааны дотор зориулалтын дагуу ашиглаагүй байна. /Хавсралт 1/

Эдгээр газраас Мөрөн сумын 10 дугаар баг 14 дүгээр гудамжны баруун талд байрлах халуун усны зориулалт бүхий 1,2 мянган м2 газрыг эзэмшигч Ш.Амарсайхан гэрээнд заасан газар эзэмших хугацаа дууссан, тухайн газрыг зориулалтын дагуу ашиглаагүй нь Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6[30] дахь заалтыг зөрчсөн тул тухайн газрыг зориулалтын дагуу ашиглуулах зөвлөмж хүргүүллээ.

Дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтаар авсан дээрх газруудыг зориулалтын дагуу ашиглуулах талаар холбогдох эрх бүхий албан тушаалтан арга хэмжээ авч ажиллаагүй байна. /Хавсралт 1/

ГХБХБГ-аас ирүүлсэн судалгааны дүнд дараах газрууд 2 жил дараалан зориулалтын дагуу ашиглаагүй байна.

*Хүснэгт 10:*

| № | Эзэмшигч нэр | Олгосон огноо | Газрын хэмжээ /м2/ | Газрын байршил | Зориулалт | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Д.Амараа | 2010 | 900 | Бүрэнхаан сургууль зүүн талд | Эмийн сан | Хашаа барьсан эмийн сангаа бариагүй |
| 2 | Хөвсгөл дэлгэр халиун | 2010 | 154 | 15-р байрны хойд талд | Худалдаа үйлчилгээ | 2 жил дараалан ашиглаагүй |
| 3 | Г.Батцогт | 2011 | 3000 | Гурилын үйлдвэрийн зүүн талд | Үйлдвэр үйлчилгээ | Хашаа барьсан |

[29] 6.1.1-д “Хот тосгон бусад суурины газарт ”
[30] хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй.

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **4** | Н.Дамбий | 2011 | 1500 | Гурилын үйлдвэрийн зүүн талд | Үйлдвэр үйлчилгээ | Хашаа барьсан |
| **5** | Содмонгол ХХК | 2011 | 4500 | Хилэнт чиглалийн авто замын баруун талд | ШТС | 2 жил дараалан ашиглаагүй |
| **6** | Н.Бат-Эрдэнэ | 2011 | 10000 | Бүрэнхаан сургуулийн баруун тал | Орон сууц | Үйл ажиллагаа огт явуулаагүй |
| **7** | Д.Сэмжид | 2008 | 216 | 17-р байрны урд залгаа | Худалдаа үйлчилгээ | Үйл ажмллагаа огт явуулаагүй |
| **8** | Н.Батдэлгэр | 2008 | 500 | Бөхийн өргөөний урд | Худалдаа үйлчилгээ | Үйл ажмллагаа огт явуулаагүй |
| **9** | Л.Гантулга | 2008 | 57.5 | 7-р байрны зүүн хойно | | Үйл ажмллагаа огт явуулаагүй |
| **10** | Мон-Ажнай ХХК | 2008 | 35000 | Радио станцын хойд талд | Нүүрс боловсруулах үйлдвэр | Үйл ажмллагаа огт явуулаагүй |
| **11** | Н.Батмөнх | 2013 | 5000 | Радио станцын зүүн талд | Үйлдвэрлэл үйлчилгээ | Хашаа барьсан |
| | **Нийт** | | 2500 | | | |

Дээрх нэр бүхий 11 нэгж талбарыг Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6 дугаар зүйл заалтыг зөрчсөн тул тухайн газрыг зориулалтын дагуу ашиглуулах зөвлөмж хүргүүллээ.

## 2.3 Газрын төлбөрийг орон нутгийн орлогод бүрэн төвлөрүүлээгүй байна.

Монгол улсын Газрын төлбөрийн тухай хуулийн 7.1.3, 7,2 дахь заалт, Засгийн газрын 1997 оны 152 дугаар тогтоолоор Мөрөн суманд нэг га газрын суурь үнэлгээг 50.0 сая төгрөг, жилийн төлбөрийн доод хязгаарыг 50.0 мянган төгрөг, дээд хязгаарыг 100.0 мянган төгрөгөөр тогтоосон байна.

Мөрөн сум нь Газрын төлбөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3-д заасан шаардлагыг харгалзан тооцсон итгэлцүүрийг ***хэрэглэх газрын зааг, хязгаар, итгэлцүүрийн тоон утгыг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно***”, гэж заасны дагуу Мөрөн сумын ИТХТ-ийн 2012 оны 26 дугаар тогтоол, 2014 оны 49 дүгээр тогтоолоор газрын төлбөрийн хувь хэмжээг тогтоосон боловч газрын жилийн *төлбөрийн хэмжээг* Засгийн газраас тогтоосон жилийн төлбөрийн *дээд хязгаараас хэтрүүлэн тогтоосон* байна.

Мөрөн сумын ИТХТ-ийн 2012 оны 26 дугаар тогтоол, 2014 оны 49 дүгээр тогтоолоор газрын төлбөрийн хувь хэмжээг тогтоосон боловч газрын жилийн *төлбөрийн хэмжээ*

Хүснэгт 11:

| № | Газар эзэмшилт, ашиглалтын зориулалт | 1-р бүс | | 2-р бүс | | ЗГ-ын 1997 оны 152-р тогтоолын 2-р хавсралт | | Зөрүү | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Итгэл цуур | 1м2 газрын төлбөр /төг/ | Итгэл цуур | 1м2 газрын төлбөр /төг/ | Итгэлц уур | 1м2 газрын төлбөр /төг/ | 1-р бүс | 2-р бүс |
| 1 | Иргэний аж ахуйн зориулалт | 0.5 | 25.0 | 0.4 | 20.0 | 0.1-0.2 | 5.0-10.0 | 15.0 | 10.0 |
| 2 | Төсөвт байгууллага | 0.6 | 30.0 | 0.6 | 30.0 | 0.1-0.2 | 5.0-10.0 | 20.0 | 20.0 |
| 3 | Худалдаа бүх төрлийн үйлчилгээ | 0.8 | 40.0 | 0.6 | 30.0 | 0.1-0.2 | 5.0-10.0 | 30.0 | 20.0 |
| 4 | Аж ахуйн үйл ажиллагаа /Худалдаа үйлчилгээнээс бусад/ | 0.8 | 40.0 | 0.6 | 30.0 | 0.1-0.2 | 5.0-10.0 | 30.0 | 20.0 |
| 5 | Нефтийн бүтээгдэхүүний агуулах, ШТСтанц | 1 | 50.0 | 1 | 50.0 | 0.1-0.2 | 5.0-10.0 | 40.0 | 40.0 |
| 6 | Авто машины граж, | 1 | 50.0 | 0.8 | 40.0 | 0.1-0.2 | 5.0-10.0 | 40.0 | 30.0 |
| 7 | Дулаан хобоо эрчим хүч | 0.7 | 35.0 | 0.5 | 25.0 | 0.1-0.2 | 5.0-10.0 | 25.0 | 15.0 |
| 8 | Нисэх онгоцны буудал | - | 0.0 | 0.4 | 20.0 | 0.1-0.2 | 5.0-10.0 | 0.0 | 10.0 |
| 9 | Нам, төрийн бус байгууллага | 0.4 | 20.0 | 0.3 | 15.0 | 0.1-0.2 | 5.0-10.0 | 10.0 | 5.0 |
| 10 | Шашин, сум хийд | 0.5 | 25.0 | 0 | 0.0 | 0.1-0.2 | 5.0-10.0 | 15.0 | 0.0 |
| 11 | Бүх төрлийн үйлдвэрлэл ХАА-гаас бусад | 0.7 | 35.0 | 0.6 | 30.0 | 0.1-0.2 | 5.0-10.0 | 25.0 | 20.0 |
| 12 | ХАА-н үйлдвэрлэл | 0.8 | 40.0 | 0.2 | 10.0 | 0.1-0.2 | 5.0-10.0 | 30.0 | 0.0 |
| 13 | Өмчлүүлэх газрын үнэ | 1 | 5000.0 | 0.6 | 3000.0 | 0.1-0.2 | 5.0-10.1 | 4990.0 | 2990.0 |

Хүснэгтээс харахад 1,2 дугаар бүсэд 1м2 газрын үнэлгээг 5-4990 төгрөгөөр илүү тогтоон мөрдөж байна.

Мөрөн сумын 2013 он, 2014 он , 2015 оны эхний хагас жилийн байдлаар газрын төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийн мэдээг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 12: / сая төгрөгөөр/

| № | Он | Төвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| 1 | 2013 | 76,0 | 127,8 | 51,8 |
| 2 | 2014 | 147,4 | 109,7 | -37,7 |

Хүснэгтээс харахад газрын төлбөр 2013 онд 51,8 сая төгрөгөөр давж, сүүлийн 2 жилд 5,7-37,7 сая төгрөгөөр тасарсан үзүүлэлтэй байгаа нь он тус бүрт газрын төлбөрийг үндэслэлтэй төлөвлөж,

| | | | | |
|---|---|---|---|---|
| **3** | 2015 оны эхний хагас жил | 60,0 | 54,3 | -5,7 |

тухайн газрын төлбөрийг бүрэн оруулж чадахгүй байна.

Мөрөн сумын газрын төлбөрийн орлогыг дараах байдлаар бүрдүүлсэн байна.

Хүснэгт 13: /сая төгрөг/

| № | Газрын төлбөрийн орлогын төрөл | 2013 он /сая.төг/ | | 2014 он /сая.төг/ | | 2015 оны 6 сарын 25-ны байдлаар | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Орлогын дүн | хувь | Орлогын дүн | хувь | Орлогын дүн | хувь |
| 1 | Аж ахуйн нэгжээс | 120,8 | 94,5 | 103,0 | 93,8 | 51.8 | 95,4 |
| 2 | Гэр хорооллоос | 5,2 | 4,0 | 5,9 | 5,3 | 1.8 | 3,3 |
| 3 | Суурь үнэ | 1,8 | 1,4 | 0,8 | 0,7 | 0.7 | 1,3 |
| | Нийт | 127,8 | 100 | 109,7 | 100 | 54.3 | 100 |

**Хүснэгтээс харахад:** Газрын төлбөрийн орлогын ихэнх хувийг аж ахуйн нэгжийн эзэмшлийн газрын төлбөрөөс оруулж байгаа ба гэр хорооллын эзэмшлийн газрын төлбөрийг бүрэн оруулаагүй байна.

Хүснэгт №2-д үзүүлсэн суурь хураамжийн дүнд:

- Өмнөх онуудад дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт явуулалгүй олгосон газруудаас газрын суурь үнийг нөхөж төлүүлсэн дүн
- Газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтаас орсон орлогын дүн багтаж байна.

Газрын тухай хуулийн 33.1.2. “Иргэнд гэр бүлийн хэрэгцээнд үнэгүй эзэмшүүлэх болон үнэгүй эзэмшүүлэх хэмжээнээс илүү газар эзэмших хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх асуудлыг тухайн шатны Засаг дарга дуудлага худалдаа, төсөл шалгаруулах зарчмаар шийдвэрлэнэ.” гэж заасан бөгөөд энэ заалтыг зөрчин зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү гарсан хэмжээнд нь **ногдох суурь үнийг** төлүүлэн газар олгосон.

Газрын төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг сүүлийн 4-н жилээр харьцуулан үзвэл жил бүр төсөвт төвлөрүүлсэн орлогын хэмжээ өсөн нэмэгдсээр байгаа ба зарим ААНБ нь *төлбөрөө дутуу* төлсөн байна. Газрын төлөлтийн орлогыг графикаар харуулбал:



### Газрын төлбөрийн орлого

Мөрөн суманд гэр бүлийн хамтын хэрэгцээний зориулалтаар эзэмшиж байгаа газрын төлбөрийн тооцоо дараах байдалтай байна.

Хүснэгт 14: /сая төгрөг/

| 2013 он | | | 2014 он | | |
|---|---|---|---|---|---|
| Аудитаар тооцсон газрын төлбөр | Төлбөрийн орлого | Дутуу төлөлт | Аудитаар тооцсон газрын төлбөр | Төлбөрийн орлого | Дутуу төлөлт |
| 20,9 | 5.2 | 15.7 | 21,7 | 5,9 | 15,8 |

**Хүснэгтээс харахад:** 2013-2014 онуудад айл өрхөөс авах газрын төлбөрийг дутуу тооцсон байна.

Аж ахуйн нэгж байгууллагуудын хувьд:

- Инженерийн шугам сүлжээтэй бүсээс гадна байгаа 217 аж ахуй болон мод үржүүлэг, хүнсний ногооны зориулалттай 231,67 га газар эзэмшдэг бөгөөд газрын төлбөр 45,7 сая төгрөг
- Инженерийн шугам сүлжээтэй бүс доторхи 89 төрийн захиргааны байгууллагууд 75,0 га газар эзэмшдэг ба газрын төлбөр 20,9 сая төгрөг
- Инженерийн шугам сүлжээтэй бүс доторхи 355 аж ахуйн зориулалттай байгууллагуудад 147,8 га газар эзэмшдэг ба газрын төлбөр 75,0 сая төгрөг

нийт 661 аж ахуйн нэгж байгууллагын 454,5 га газрын төлбөр 141,7 сая төгрөг ногдуулсан байна.

Төлбөр төлөөгүй байгууллагын судалгаа

Хүснэгт 15: /мян.төгрөг/

| № | Үзүүлэлт | 2013 | 2014 | 2015 | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | Инженерийн шугам сүлжээтэй төрийн захиргааны байгууллагууд | 637.2 | 1817.8 | 908.9 | 3363.9 |
| 2 | Аж ахуйн байгууллагууд | 9596 | 25727.9 | 12864 | 48187.9 |
| 3 | Төмс хүнсний ногоо болон үйлдвэр үйлчилгээ | 6744.2 | 3509.8 | 1925.05 | 12179.05 |
| 4 | **Нийт дүн** | **16977.4** | **31055.5** | **15697.9** | **63730.8** |

Газрын төлбөрөө бүрэн төлөөгүй газар эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад */Дэлгэрэнгүйг Хавсралт №15/* **Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн** 40.1.5. /эрхийн гэрчилгээ эзэмшигч газрын төлбөрөө хугацаанд нь бүрэн төлөөгүй/ үндэслэлээр аймаг, сумын засаг дарга нар 40.1[31]-т 40,2[32] заалтаар гэрчилгээг хүчингүй болгох, захирамж гаргаж эрх бүхий этгээдэд мэдэгдэх гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, тодорхой арга хэмжээ аваагүй байна.

Аудитаар 2013-2014 онд газрын төлбөрөө хугацаанд нь бүрэн төлөөгүй аж ахуйн нэгж байгууллагуудын газрын төлбөрийг нөхөн төлүүлж аймгийн орон нутгийн орлогод төвлөрүүлэхээр нийт 48032,9 мянган төгрөгийн ***төлбөрийн акт*** тогтоож байна.

Инженерийн шугам сүлжээтэй газарт Аймгийн Засаг даргын захирамжаар олгогдсон газрууд Мөрөн сумын газрын бүртгэл, судалгаанд байхгүй байна. Тухайлбал:

[31] Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга дараахь тохиолдолд газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгоно:

[32] Энэ хуулийн 40.1-д заасан үндэслэл тогтоогдвол аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга эрхийн гэрчилгээг хүчингүй болгосон захирамж гаргаж, энэ тухайгаа эрхийн гэрчилгээ эзэмшиж байсан буюу түүнийг барьцаалсан этгээдэд мэдэгдэнэ.

Мөрөн суманд бүртгэлгүй нэгж талбарын судалгаа

Хүснэгт 16: /мянган төгрөг/

| № | Оноосон нэр | Баг | Газрын хэмжээ /га/ | Зориулалт | Ноогдуулалт | 2013 он | 2014 он | 2015 он | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Ц.Баттогтох | 7-р баг | 0.09 | Үйлчилгээ | 36.6 | | | 36.6 | 36.6 |
| 2 | Оюунчимэг | 8 | 0.01 | Үйлчилгээ | 4.0 | | | 4.0 | 4.0 |
| 3 | Д.Ганбаатар | 13 | 0.3 | Интернет мэдээлэл төв | 94.5 | | | 94.5 | 94.5 |
| 4 | Ц.Мэндээ | 7 | 0.08 | Худалдаа үйлчилгээ | 32.0 | | | 32.0 | 32.0 |
| 5 | Н.Сарантуяа | 7 | 1 | Орон сууц | 400.0 | | | 400.0 | 400.0 |
| 6 | Д.Мөнхсайхан | 13.16. 25 | 0.4 | Мод боловсруулах | 189.6 | | | 189.6 | 189.6 |
| 7 | О.Эрдэнбат | 8 | 0.2 | Автограж | 119.9 | | | 119.9 | 119.9 |
| 8 | Л.Уранцэцэг | 13 | 0.07 | Өлөнгийн цех | 28.0 | | | 28.0 | 28.0 |
| 9 | А.Амар | 8 | 0.04 | Худалдаа үйлчилгээ | 1.6 | | | 1.6 | 1.6 |
| 10 | П.Сандагсүрэн | 9 | 0.4 | Үйлдвэр үйлчилгээ | 184.4 | | | 181.4 | 181.4 |
| 11 | Б.Бат-Эрдэнэ | 8 | 0.04 | Ногоон байгууламж авто зогсоол | 19.2 | | | 19.2 | 19.2 |
| 12 | Г.Батцогт | 7 | 0.6 | Аж ахуй | 240.0 | | | 240.0 | 240.0 |
| 13 | Цэрэндолгор | 8 | 0.05 | Худалдаа үйлчилгээ | 21.0 | | | 21.0 | 21.0 |
| 14 | Цэрэндэжид | 8 | 0.1 | Орон сууц | 18.0 | | | 18.0 | 18.0 |
| 15 | Батдаваа | 7 | 0.4 | Уран мандал хороолол | 162.0 | | | 162.0 | 162.0 |
| 16 | Геологи | 7 | | 30 айлын орон сууц | Захирамж байхгүй | | | | |
| 17 | Мон-Ажнай Л.Ганболд | 8 | | клонк | олдоогүй | | | | |
| 18 | Лхагвамаа | 1 | 0.01 | Масс төв sity shop | 4.8 | | | 4.8 | 4.8 |
| 19 | Б. Сарантуяа | 1 | 0.1 | 8 баг 17 ба | 51.8 | | | 51.8 | 51.8 |
| 20 | Б.Мөнхцэцэг | 8 | 0.01 | | 4.8 | | | 4.8 | 4.8 |
| Дүн | | | 3.9 | 0 | 1612 | 0 | 0 | 1609 | 1609 |

Дээрх зөрчлүүдээс харахад: Мөрөн суманд газрын төлбөр хариуцсан, бусад харилцаатай холбоотой 3 мэргэжилтэн, ГХБХБГ-т 1 мэргэжилтэн ажиллаж байгаа боловч газрын төлбөр тооцож ногдуулах, барагдуулах, чиг үүргээ хангалттай хэрэгжүүлээгүй, ажлын уялдаагүй, удирдлага, зохион байгуулалтын хувьд *хангалтгүй* байна.

### Үнэт цаасны талаар:

Газрын тухай хуулийн 23.3-д аймгийн газрын албаны эрх, үүргийн дагуу Мөрөн сумын инженерийн шугам, сүлжээтэй бүсэд аймгийн Засаг даргын шийдвэрийг үндэслэн иргэн, ААН, байгууллагад газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгож байна.

ГХБХБГ-ын Гэр бүл хамтын хэрэгцээний эрхийн гэрчилгээ, Төрийн байгууллагын газрын эрхийн гэрчилгээ, ААНБ-ыг газрын эрхийн гэрчилгээ, газар ашиглах гэрчилгээний зарцуулалтыг шалгаж, хяналтын тооллого хийхэд 5 ш 3850 төгрөгийн газар эзэмших гэрчилгээ илүүдэж, 4 ш 3080 төгрөгийн гэр бүлийн хамтын хэрэгцээний эрхийн гэрчилгээ, 12ш 9295,56 төгрөгийн ААНБ-ын газрын эрхийн гэрчилгээ буюу нийт 16 ш 12375,56 төгрөгийн гэрчилгээ дутагдаж байна.

### Үнэт цаасны тооцоо

Хүснэгт 17:

| № | Үнэт цаасны нэр | Хэмжих нэгж | Нэг бүр ийн үнэ | Тайлангийн үлдэгдэл 2015,04,01 | | Гэрчилгээ зарцуулалт, шаардах хуудсаар 2015 оны 4.5.6 сар | | Байх ёстой үлдэгдэл тооцоо 2015,06,24 | | | Тооллогоор 2015,06,24 | | | Аудитын болон үлдэгдэл тооцооны зөрүү | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | | | | Илүү | | Дутуу | |
| | | | | Тоо | Үнэ | Тоо | Үнэ | Нэгж үнэ | Тоо | Үнэ | Нэгж үнэ | Тоо | Үнэ | ш | Үнэ | ш | Үнэ |
| 1 | Гэр бүлийн хамтын хэрэгцээний эрхийн гэрчилгээ | ш | 770 | 1810 | 1393.7 | 1071 | 824.7 | 766 | 739 | 566.0 | 770 | 735 | 566.0 | | | 4 | 3.1 |
| 2 | Төрийн байгууллагын газрын эрхийн гэрчилгээ | ш | 770 | 190 | 146.3 | 7 | 5.4 | 770 | 183 | 140.9 | 770 | 183 | 140.9 | | | | |
| 3 | ААНБ-ын газрын эрхийн гэрчилгээ | ш | 775 | 341 | 264.1 | 31 | 24 | 745 | 310 | 230.8 | 775 | 298 | 230.8 | | | 12 | 9.3 |
| 4 | Газар ашиглах гэрчилгээ | ш | 739 | 147 | 108.6 | 0 | 0 | 796 | 147 | 117.0 | 770 | 152 | 117.0 | 5 | 3,9 | | |
| | **Бүгд дүн** | | | 2488 | 1912.7 | 1109 | 854.1 | | 1379 | 1054.7 | | 1368 | 1054.7 | 5 | 3,9 | 16 | 12.4 |

## 2.4 Газар олголт болон газрын төлбөр ногдуулалт, төвлөрүүлтэд тавьж буй хяналт үр дүнгүй байна.

Мөрөн сумын газар олголт, ашиглалт, газрын төлбөр ногдуулалт, гүйцэтгэлтэй холбоотой дараах зөрчил дутагдал илэрч байна. Үүнд:

- Аймгийн Хот байгуулалтын нэгдсэн төлөвлөгөөг ИТХТ-ийн хурлаар баталсан боловч магадлангаар орж баталгаажаагүй ба өдий болтол холбогдох байгууллагуудын гар дээр очоогүй.
- Мөрөн сумын инженерийн шугам сүлжээ бүхий газарт худалдаа үйлчилгээний чиглэлээр газар олгохдоо дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтгүйгээр шууд олгосон
- Газрын төлбөрийн тооцоолол бодит байдалтай нийцэхгүй байгаа

- Газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, ААН-ийн бүртгэл, 2-оос дээш жил ашиглахгүй байгаа газрын судалгаа байхгүй байгаа зэргээс харахад энэ чиглэлд тавих хяналт нилээд орхигдсон байгааг харуулж байна.

Аймгийн МХГ-ын газрын БОГХГЗЗ хяналтын улсын байцаагч Л.Энхцэцэгийн ажлын тайлантай танилцахад 2014 онд Мөрөн сумын Засаг даргын захирамжаар 2012-2013 онд газар олгосон байдалд хяналт хийж дараах албан шаардлагыг хүргүүлсэн байна. Үүнд:

- Сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, газрын сангийн зурагтай болох, тухайн жилийн газар зохоин байгуулалтын төлөвлөгөөний дагуу газар олгож байх
- Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой бусад эрхийн улсын бүртгэлийн талаарх өөрчлөлтийн мэдээллийг газрын мэдээллийн санд бүртгэх
- Зохих зөвшөөрөлгүй газар эзэмшиж байгаа зөрчлийг арилгуулах
- Дотоод хяналтыг зохион байгуулах
- Байгал орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийлгэх
- Геодезийн цэг тэмдэгтийг өтгөрүүлэх арга хэмжээ авах
- Газрын нэгдмэл сангийн тайланд газрын улсын бүртгэл, ашиглалт хамгаалалтын байдалд зургийг хавсаргаж байх зэрэг албан шаардлагуудыг хүргүүлсэн байна.

Дээрх гарч байгаа зөрчил гүйцэтгэлийн аудитаар дахин давтагдаж байгаа нь хяналт шалгалтын үр дүн гарахгүй байгаа, нөгөө талаар сумын ИТХ-аас тухайн жилийн баталсан газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтэд тавих хяналт сул байгааг харуулж байна.

2013, 2014 оны байдлаар газрын төлбөр төлөөгүй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын бүртгэл судалгааг хянахад Мөрөн сум 48,0 сая төгрөг, Татварын хэлтсийн бүртгэлд 5,4 сая төгрөг төлөөгүй гэсэн бүртгэлтэй байна. Үүнээс харахад Мөрөн сум, аймгийн Татварын хэлстийн ажлын уялдаа холбоо хангалтгүй байгааг харуулж байна.

Татварын хэлтэс, Мөрөн сумын газрын даамлын тайлан мэдээг тулган шалгахад ногдуулалт, төлөвлөгөөг бодитой хийгээгүй, гүйцэтгэлийг бүрэн хангуулаагүй, тайлагнал үнэн зөв биш, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс ногдуулсан төлбөрийг хугацаанд авдаггүй, өр, авлага үүсгэж тайлагнаагүй байна. Энэ нь газрын төлбөрийн ногдуулалт, төлөвлөгөө, гүйцэтгэлд аймгийн Татварын хэлтсээс тавих хяналт туйлын хангалтгүй гэж аудитаар үзэж байна.




### 3.1 Аудитын зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн аудитын газрын 2012 онд гүйцэтгэсэн "Мөрөн сумын газар олголт" ХөААГ-ГА1/2011/11-ГА-аар эрх бүхий албан тушаалтнуудад 11 зөвлөмж өгсөн байна.

Аудитын зөвлөмжийн биелэлт 63 хувьтай бөгөөд дараах зөвлөмжүүдийг бүрэн хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

1. Эзэмшигч нь давхардаж маргаантай байсан Г.Ганбилэг, Д.Ширэндэв, Л.Суваров, Б.Дагвадорж, П.Уранчимэг зэрэг иргэдийн газрын маргааныг АЗД-ын 2013 оны А/248 тоот захирамжаар Г.Ганбилэгт /13 дугаар багт 500м2/ газар шинээр олгосон, "Центр" дэлгүүрээс хойш түүхий эдийн зах хүртэл/хуучнаар/ Хот тохижилт, үйлчилгээний төв болон "Найдвар сервес" ХХК-тай эзэмшигч нь давхардсан газрын маргаан шүүхээр шийдвэрлэгдсэн байна. Харин "Цагаан-Уул Тэрхэн" ХХК-тай давхардуулан олгосон газрын маргааны асуудлаар 2014 оны 03 дугаар сарын 03 ны өдөр Улсын Дээд Шүүхийн 23 дугаар тогтоол гарсан боловч шийдвэрлэгдээгүй, шүүхийн шатанд байна.
2. Газрын дуудлага худалдааг зохион байгуулаагүй газар олгосон, газрын хэмжээг зөвшөөрөлгүй нэмэгдүүлэн олгосон зэрэг зөрчил давтагдсаар байгаа нь өмнөх аудитын зөвлөмж хэрэгжээгүй байгааг харуулж байна. Аудитаар дуудлага худалдаа зохион явуулаагүй 14 иргэнд инженерийн шугам сүлжээ бүхий газар олгосон нь тогтоогдсон байна. /*тайлангийн 1.3 бүлгээс*/
3. Газрын төлбөрийн хувь хэмжээг хуульд нийцүүлэн тогтоогоогүй байна.
4. Газрын төлбөр ногдуулалт, төвлөрүүлэлтэд тавьж буй хяналт хангалтгүй байгаагаас эрх бүхий байгууллагуудын тоо, мэдээлэл зөрүүтэй хэвээр байна. /*тайлангийн 2.3 дэхь бүлгээс*/

Аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлагдсан боловч ашиглагдаж эхлээгүй, 2016 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд ашиглахад бэлэн болсон, Газрын төлбөрийн орлого, дуудлага худалдааны орлогыг тус тусад данс нээж тайлагнаж байгаа нь түүний төлөвлөлт, гүйцэтгэлд дүн шинжилгээ хийхэд хялбар болсон хэдий ч тэдийлэн шинжилгээ хийдэггүй, орон нутгийн орлогын төлөвлөлтөнд ашигладаагүй нь аудитаар тогтоогдлоо.

### 3.2 *shilendans.gov.mn* сайтад мэдээллийг *Засгийн газрын 2014 оны 384 дүгээр тогтоолоор баталсан "Журам"-д заасан агуулга, нийтлэг стандартад нийцүүлэн цаг хугацаанд тавьж хэвшээгүй байна.*

Төрийн аудитын байгууллага нь Шилэн дансны тухай хуулийн 8.1[33], 8.3[34]-т заасан эрх, үүргийнхээ дагуу гүйцэтгэлийн аудитаар Мөрөн сумын ЗДТГ болон ГХБХБГ-ын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хяналт хийв.

- Мөрөн сумын ЗДТГ-ын хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах албан тушаалтны ажлын байрны тодорхойлолтод холбогдох мэдээллийг ***Засгийн газрын 2014 оны 384 дүгээр тогтоолоор баталсан "Журам"-д заасан агуулга, нийтлэг стандартад нийцүүлэн*** нэгдсэн сайтад тавьж байх үүрэг хүлээлгэн өөрчлөлтийг оруулж өгсөн байна. Эрх

[33] Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны ИТХ, ИНХ, төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ.
[34] Төрийн аудитын байгууллага нь өөрийн санаачилгаар шилэн дансны мэдээлэлд аудит хийж болно.

бүхий ажилтан Б.Сүнжидмөнх нь холбогдох мэдээллүүдийг *shilendans.gov.mn* сайтад байршуулсан ба “Ил тод”-ын самбар хийж иргэд мэдээлэл авах боломжтой газар байршуулан ажиллаж байна.

- ГХБХБГ-ын хувьд Шилэн дансанд мэдээлэл тавих албан тушаалтныг томилоогүй ба Шилэн дансны нэгдсэн сайтад мэдээлэл оруулах үүргийг нягтлан бодогч хариуцан оруулж байгаа гэсэн мэдээллийг өгч байна.

Дээрх 2 байгууллагын shilendans.gov.mn сайтад оруулсан мэдээллийн *талаар:*

Хүснэгт 18:

| Үзүүлэлт | Мөрөн сум | ГХБХБГазар |
|---|---|---|
| Батлагдсан төсөв | Оруулсан | Оруулаагүй |
| Төсөв ба гүйцэтгэл | Оруулсан | Оруулсан |
| Төсвийн зарлагын хэмнэлт | Оруулсан | Оруулсан |
| 5 сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлага | Оруулаагүй | Оруулсан |
| Хөрөнгийн болон концессын зүйлийн зарлага | Оруулсан | Оруулсан |
| Төсвийн орлого | Оруулсан /хангалтгүй/ | Оруулсан |
| Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл | Оруулсан /мэдээлэл дутуу/ | Оруулсан |
| Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн их хэмжээний хэлцлийн талаарх мэдээлэл | Оруулсан | Оруулсан |
| Тендерийн шалгаруулалт | Оруулсан | Оруулсан |
| 5 сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт | Оруулсан | Оруулсан |
| Хандив тусламжын хэмжээ түүний зарцуулалт | Оруулаагүй | Оруулаагүй |
| Байгууллалгын өмч хөрөнгөтэй холбоотой шийдвэрийн жагсаалт | Мэдээлэл дутуу оруулсан байна. | Мэдээлэл дутуу оруулсан байна. |
| Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авч буй эрх бүхий этгээдийн жагсаалт | Оруулсан | Оруулсан |

Аудитын хугацаанд Шилэн дансны нэгдсэн сайтад мэдээлэл оруулах асуудлыг удаа дараа анхааруулан, аудитын төгсгөлд нэгдсэн сайтад оруулсан мэдээллийг дахин хянаж үзсэн болно.

Дээрх хүснэгтээс харахад мэдээллийг оруулж байгаа боловч дараах зөрчил байна. Үүнд:

- Шилэн дансанд тавигдах мэдээлэлийг бүрэн гүйцэт оруулахгүй байна.
- Засгийн газрын тогтоолоор батлагдсан “Журам”-д заагдсан нийтлэг стандарт, агууллагад нийцүүлэн тавихгүй байна.
- Газрын асуудалтай холбоотой захирамж шийвэрүүдийг ил тод мэдээллээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалтуудын дагуу мэдээллийг нэгдсэн сайт болон ил тодын самбарт байршуулан мэдээлж байгаа боловч Засгийн газрын 2014 оны 384 дүгээр тогтоолоор батлагдсан “Журам”-д заасан нийтлэг стандарт, агуулгад нийцүүлэн тавьж хэвшихгүй байна.

***Аудитаар газрын төлбөрөө хугацаанд нь төлөөгүй байгууллага аж ахуйн нэгжид 48,0 сая төгрөгийн төлбөрийн акт, дуудлага худалдаа төсөл сонгон шалгаруулалтгүйгээр олгосон газруудын гэрчилгээг цуцалж, дахин төлөвлөлтөнд оруулах 2 албан шаардлага, хууль журам зөрчин гаргасан эрх зүйн актуудыг хүчингүй болгох 1 албан шаардлага хүргүүлж байна.***

# Дүгнэлт

**Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.**

1. Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг ГХБГЗЗГ-н даргын 2010 оны 497 дугаар тушаалаар баталсан "Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал"-н дагуу болон Мөрөн хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулах, Мөрөн хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний барилга байгууламж төлөвлөөгүй газарт хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийлгэх шаардлагатай байна.
2. Аймгийн Засаг даргын шийдвэрээр зохион байгуулах, олгох газрын төлөвлөгөөг аймгийн ИТХ баталж, Мөрөн хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаагүй газарт газар олгох асуудлыг зогсоох нь зүйтэй байна.
3. Газрын төлбөрийн хувь хэмжээг ЗГ-ын 1997 оны 152 дугаар тогтоолоор баталсан хувь хэмжээнээс өндөр тогтоосон, газрын төлбөрийн ногдуулалт, төвлөрүүлэлтэд аймгийн Татварын хэлтэс хяналт тавиагүй, ГХБХБГазар, Мөрөн сумын ЗДТГазрын ажлын уялдаа холбоо хангалтгүй байна.
4. Өмнөх аудитаар болон МХГ-ын хяналт шалгалтаар гарсан зөрчил, дутагдал гүйцэтгэлийн аудитаар дахин давтагдаж байгаа нь хяналт шалгалтын үр дүн гарахгүй байгаа, нөгөө талаар сумын ИТХ-аас тухайн жилийн баталсан газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийг он тус бүрт нь хянахгүй байна.
5. Аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, инженерийн шугам сүлжээ бүхий газарт дуудлага худалдаа явуулалгүй газар олгосон, давхардуулан олгосон газрын асуудал эцэслэн шийдвэрлэгдээгүй байна.
6. Мөрөн сумын Засаг дарга, аймгийн Засаг дарга нар Төрийн байгууллагын зайлшгүй хэрэгцээнд эзэмшүүлсэн, төрийн өөрийн өмчид хамаарах үл хөдлөх эд хөрөнгө болох "газар"-ыг ИТХ, Төрийн өмчийн хорооны шийдвэргүйгээр бусдад эзэмшүүлсэн байна.
7. Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалтуудын дагуу мэдээллийг нэгдсэн сайт болон ил тодын самбарт байршуулан мэдээлж байгаа боловч Засгийн газрын 2014 оны 384 тоот тогтоолоор батлагдсан "Журам"-д заасан нийтлэг стандарт, агуулгад нийцүүлэн мэдээллэхгүй байна.

# Аудитын зөвлөмж

**Аудитын дүнд үндэслэн дор дурдсан байгууллагад дараах зөвлөмжийг өгч байна.**

**Аймгийн ИТХ-ын дарга Т.Болдбаатар-т:**

1. Газар зохион байгуулалтын Ерөнхий төлөвлөгөөний дагуу тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг батлах, уг төлөвлөгөөнд үндэслэн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг баталж байхыг сумдын ИТХ-д зөвлөж ажиллах, өмнөх жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг ИТХ-д оруулахдаа Мэргэжлийн хяналтын газрын дүгнэлтийн хамт оруулж байх.
2. Мөрөн хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу боловсруулагдсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг тухай бүр нь батлах.
3. Төрийн байгууллагын зайлшгүй хэрэгцээнд эзэмшүүлсэн, төрийн өөрийн өмчид хамаарах газар буюу үл хөдлөх хөрөнгийг орон нутгийн өмчид бүртгэж, хяналт тавих, аудитаар илрүүлсэн зөрчилтэй холбогдуулан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан ИТХ-ын бүрэн эрхэд хамаарах шийдвэргүйгээр төрийн өөрийн өмчийн газрыг бусдад эзэмшүүлсэн Засаг даргын шийдвэр хууль бус эсэхийг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмаар шийдвэрлүүлэх,

**Аймгийн Засаг дарга А.Эрдэнэбаатар-т:**

1. Газар зохион байгуулалтын Ерөнхий төлөвлөгөөний дагуу, Мөрөн хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөтэй уялдуулан тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулан аймгийн ИТХ-д өргөн мэдүүлж, батлуулах.
2. Мөрөн хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний барилга байгууламж төлөвлөөгүй газарт хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийлгэн, ИТХ-аар батлуулах.
3. Дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтгүйгээр эзэмшүүлсэн газруудын эзэмших эрхийг хүчингүй болгож, чөлөөлөгдсөн газрыг төлөвлөгөөнд тусгуулан Газрын тухай хуулийн 21.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд 21.3.2 дахь заалтыг баримтлан иргэн, аж ахуй нэгж, байгууллагад эзэмшүүлэх.
4. Төрийн байгууллагын зайлшгүй хэрэгцээнд эзэмшүүлсэн, төрийн өөрийн өмчид хамаарах газрыг орон нутгийн ИТХ-ын шийдвэрийг үндэслэн эзэмшүүлж байх
5. Мөрөн сумын инженерийн шугам сүлжээтэй бүсэд иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар эзэмшүүлэхдээ шударга ёс, тэгш байдлыг хангах зарчим, хууль, эрх зүйд нийцүүлж байх.

**Мөрөн сумын ИТХ-д :**

1 Аймгийн ИТХ-аар баталсан тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг батлах.

2 Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу газар олгож байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах.

3 ИТХ-ын хуралдаанаар баталсан тогтоолд ИТХ-ын тэргүүлэгчдийн шийдвэрээр өөрчлөлт оруулахгүй байх.

**Мөрөн сумын Засаг дарга Ц.Гансүх-д:**

1. Газрын тухай хуулийн 21-р зүйлийн 21.4.3 дахь заалтыг баримтлан иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлж байх.
2. Газрын төлбөрийн хувь хэмжээг хууль, журамд нийцүүлэн сумын ИТХ-аар шинэчлэн батлуулах.
3. ЗДТГ-т газрын төлбөр хураалтын мэргэжилтний ажлын байрны чиг үүргийн дагуу ажиллуулж, үр дүнг бодитой тооцох.

**Мөрөн сумын газрын даамал З.Нямбаяр-т:**

1. Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг газар зохион байгуулалтын үндсэн баримт бичиг болон ГХБГЗЗГ-н даргын 2010 оны 497 дугаар тушаалаар баталсан “Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-н дагуу боловсруулах.
2. Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу газар олгох асуудлаар тухайн шатны Засаг даргад зөвлөж ажиллах.
3. Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалт бүхий газруудад дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтаар газар эзэмшүүлэхдээ Газрын тухай хуулийн 34.2, 34.7 дахь заалтуудыг тус тус хэрэгжүүлж ажиллах.
4. Дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтаар газар эзэмшүүлсэн иргэн, аж ахуй нэгж, байгууллагуудтай Газрын тухай хуулийн 34.8 дахь заалтыг баримталж ажиллах.
5. Гэрээнд тусгагдсан газар эзэмших хүчинтэй хугацаа нь дууссан, зориулалтын дагуу ашиглаагүй иргэн, аж ахуй нэгж, байгууллагуудтай Газрын тухай хуулийн 40.1.6 дахь заалтыг баримталж ажиллах

**ГХБХБГ-ын дарга Н.Бямбадорж-д:**

1. Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг газар зохион байгуулалтын үндсэн баримт бичиг болон ГХБГЗЗГ-н даргын 2010 оны 497 дугаар тушаалаар баталсан “Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-н дагуу боловсруулах.
2. Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу газар олгох асуудлаар тухайн шатны Засаг даргад зөвлөж ажиллах.
3. Эзэмшил нь давхардаж байгаа, зориулалт бусаар ашиглаж байгаа газрын судалгааг гарган, асуудлыг хуулийн дагуу шийдвэрлүүлэх

4. Иргэн, аж ахуй нэгж, байгууллагын эзэмшиж буй газрын хэмжээг нэмэгдүүлж газар олгохдоо Газрын тухай хуулийн 33.1.2 дахь заалтыг баримтлан эзэмшүүлэх.
5. Дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтаар газар эзэмшүүлсэн иргэн, аж ахуй нэгж, байгууллагуудтай Газрын тухай хуулийн 34.8 дахь заалтыг баримталж ажиллах.
6. Гэрээнд тусгагдсан газар эзэмших хүчинтэй хугацаа нь дууссан, зориулалтын дагуу ашиглаагүй иргэн, аж ахуй нэгж, байгууллагуудтай Газрын тухай хуулийн 40.1.6 дахь заалтыг баримталж ажиллах.

**Татварын хэлтсийн дарга В.Баяраа-д:**

1. Газрын төлбөрийн ногдуулалт, тайлагнал, төвлөрүүлэлтэд Газрын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх заалтын дагуу хяналт тавин Мөрөн сумын газрын даамалтай улирал тутам тооцоо нийлж байх

**Эрүүл мэндийн газрын дарга Л.Дамдинсүрэн-д:**

1. Аймгийн Эрүүл мэндийн газартай “Барилгын ажил гүйцэтгэх гэрээ”-ний үндсэн дээр Хөвсгөл Геологи ХК-ийн гүйцэтгэж буй 40 айлын орон сууцны барилгын газар эзэмших эрхтэй холбоотой асуудлыг аймгийн ИТХ-д тавьж Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан журамд нийцүүлэн шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

## Аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт

### Нэг. Төлбөрийн акт

/сая төгрөг/

| № | Байгууллага | Төлбөр хариуцагчийн | | Зөрчлийн товч утга | Актын дугаар | Зөрчлийн дүн /сая төг/ |
|---|---|---|---|---|---|---|
| | | Нэр | Албан тушаал | | | |
| 1 | Мөрөн сум ЗДТГ | Ц.Гансүх | Засаг дарга | 2013-2014 онд аж ахуйн нэгж байгууллагаас оруулаагүй газрын төлбөр | | 48,0 |
| | | **Нийт дүн** | | | | |

### Хоёр. Албан шаардлага

/сая төгрөг/

| № | Байгууллага | Төлбөр хариуцагчийн | | Зөрчлийн товч утга | Албан шаардлагын дугаар | Зөрчлийн дүн |
|---|---|---|---|---|---|---|
| | | Нэр | Албан тушаал | | | |
| 1 | | А.Эрдэнэбаатар | аймгийн Засаг дарга | Дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтгүй газар олгосон | | |
| 2 | | А.Эрдэнэбаатар | аймгийн Засаг дарга | Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй газарт газар олгосон, захирамжинд заагдсан байршил өөрчлөгдсөн, уг үйл ажиллагаа нь нийтийн дунд ил тод явагдаагүй | | |
| 3 | | Ц.Гансүх | Мөрөн сумын Засаг дарга | 2015 оны 06 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулагдсан дуудлага худалдаар хүчингүй болгох | | |
| | | **Нийт дүн** | | | | |

### Гурав. Бусад

/сая төгрөг/

| **№** | **Холбогдох албан тушаалтан** | **Зөрчлийн товч утга** | **Зөрчлийн дүн** |
|---|---|---|---|
| **1** | Мөрөн сумын ЗДТГ-ын газрын даамал | Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг аргачлалын дагуу боловсруулаагүй. | |

| | | | |
|---|---|---|---|
| **2** | Аймаг, Мөрөн сумын Засаг дарга, газрын даамал | Мөрөн хотын хөгжлийн төлөвлөгөөг зөрчин газар зохион байгуулалтын төлөвлөлт хийсэн, газар олгосон. | |
| **3** | Аймаг, Мөрөн сумын Засаг дарга | Дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтгүйгээр газар олгосон | |
| **4** | Аймаг, Мөрөн сумын Засаг дарга | Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг зөрчин газар олгосон. | |
| **5** | Мөрөн сумын Засаг дарга | Инженерийн шугам сүлжээ бүхий газарт газар олгосон | |
| **6** | Мөрөн сумын ИТХ, газрын даамал | Мөрөн сумын Засаг даргын захирамжаар олгосон газарт дараа жил нь нөхөн төлөвлөлт хийсэн. | |
| **7** | Мөрөн сумын газрын даамал | Дуудлага худалдаагаар газар эзэмшигчдийн хувийн хэргийн бүрдэл хангалтгүй, газрын тухай хуулийн 34.7-д заасан зайлшгүй хавсаргах баримт материалыг хавсаргаагүй байна. | |
| **8** | Мөрөн сумын газрын даамал | Дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтаар газар эзэмшүүлсэн иргэн, аж ахуй нэгж, байгууллагуудтай Газрын тухай хуулийн 34.8 дахь заалтыг баримтлахгүй байна. | |
| **9** | Аймаг, Мөрөн сумын Засаг дарга | Гэрээнд заагдсан хугацааны дотор газраа зориулалтын дагуу ашиглаагүй. | |
| | **Нийт дүн** | | |

***Зориулалтын дагуу ашиглаагүй газрууд :***

/Хавсралт 1/

| № | Баг хороо | Газрын байршил | Зориулалт | Хэмжээ | Захирамж огноо | Эзэмшигчийн нэр | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| **1** | Мөрөн сум 10-р баг | 14-р гудамжны баруун талд | Халуун ус | 1200 | 2013.05.22 | Ш.Амарсайхан Рэ65030807 | Газар нь хоосон, зориулалтын дагуу ашиглаагүй, эзэмших хугацаа нь дууссан байна. |
| **2** | Мөрөн сум 13-р баг | РӨНС-ын зүүн талд | Үйлдвэрлэл үйлчилгээ | 5000 | 2013.07. | Л.Хоролсүрэн Рд80082607 | Хашаа хатгасан, зориулалтын дагуу ашиглаж эхлээгүй. |
| **3** | Мөрөн сум 13-р баг | РӨНС-ын зүүн талд | Үйлдвэрлэл үйлчилгээ | 5000 | 2013.07. | А.Ичинхорлоо Рэ77062908 | Хашаагүй, зориулалтын дагуу ашиглаж эхлээгүй. |
| **4** | Мөрөн сум 9-р баг | 52-р гудамжны баруун үзүүр | Худалдаа үйлчилгээ | 600 | 2014.05.30 | Д.Лхагвасүрэн | Хашаагүй, зориулалтын дагуу ашиглаж эхлээгүй. |
| **5** | Мөрөн сум 1-р баг | Хатгал явах хар замын дагуу | ШТС | 5000 | 2014.05.30 | Хөвсгөл Дэлгэрхаан | Хашаагүй, зориулалтын дагуу ашиглаж эхлээгүй. |
| **6** | Мөрөн сум 1-р баг | Хатгал явах хар замын дагуу | Аялал жуулчлал | 10000 | 2014.05.30 | В.Анхбаатар | Хашаагүй, зориулалтын дагуу ашиглаж эхлээгүй. |
| **7** | Мөрөн сум 13-р баг | Хилэнт чиглэлийн авто зам баруун | Аялал жуулчлал | 2500 | 2013.09.17 | Ө.Төмөр | Хашаагүй, зориулалтын дагуу ашиглаж эхлээгүй. |
| **8** | Мөрөн сум 13-р баг | Зам ангийн ар тал | Орон сууц | 5000 | 2013.09.17 | Ө.Төмөр | Хашаагүй, зориулалтын дагуу ашиглаж эхлээгүй. |
| **9** | Мөрөн сум 13-р баг | Хилэнт чиглэлийн авто зам баруун | Аялал жуулчлал | 2500 | 2013.07.08 | С.Бурмаа | Хашаагүй, зориулалтын дагуу ашиглаж эхлээгүй. |
| **10** | Мөрөн сум 13-р баг | РӨНС-ын баруун талд | Үйлдвэрлэл үйлчилгээ | 5000 | 2013.07.08 | О.Алагхүү | Хашаагүй, зориулалтын дагуу ашиглаж эхлээгүй. |
| **11** | Мөрөн сум 13-р баг | Хилэнт чиглэлийн авто зам баруун | Аялал жуулчлал | 2500 | 2013.07.08 | Ц.Одонтуяа | Хашаагүй, зориулалтын дагуу ашиглаж эхлээгүй. |
| **12** | Мөрөн сум 13-р баг | Зам ангийн хойд талд | Нийтийн орон сууц | 5000 | 2013.07.08 | Хөвсгөл Зам | Хашаагүй, зориулалтын дагуу ашиглаж эхлээгүй. |
| **13** | Мөрөн сум 13-р баг | РӨНС-ын баруун талд | Үйлдвэрлэл үйлчилгээ | 5000 | 2013.09.17 | Ц.Төрмөнх | Хашаагүй, зориулалтын дагуу ашиглаж эхлээгүй. |

## *Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт*

| Зөвлөмжийн утга | Ирүүлсэн санал | Аудитаар тогтоосон | Биелсэн эсэх |
|---|---|---|---|
| **АИТХ-ын даргад** | | | |
| **Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг батлах** | 2013 оны 12-р сарын 05-ны ИТХ-ын ээлжит 5-р хуралдаанаар “ Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө хийлгэх тухай 10 дугаар тогтоол гаргаж 158,0 сая төгрөг баталсан. ХАА-г зохион явуулсан. | АИТХ-ын 2015 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаар батлуулсан байна. Аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлагдсан боловч 2016 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд ашиглахад бэлэн болсон байна | Биелсэн |
| **Өмнөх жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг ИТХ-ын хэрэлдээнээр оруулахдаа МХГ-ын дүгнэлттэй хамт оруулж байх** | Эрх бүхий албан тушаалтнуудад үүрэг болгосон | Жил бүрийн төлөвлөгөөг батлуулахдаа МХГ-ын дүгнэлт гаргуулдаггүй байна. | Хэрэгжээгүй |
| **Тогтоолуудын хэрэгжилтэд хяналт тавих** | 2013 оны 09 тоот тогтоолын хэрэгжилтийг хэлэлцсэн. | | Хэрэгжсэн |
| **Аймгийн засаг даргад** | | | |
| **Газрын асуудалтай холбоотой захирамжуудыг дахин хянаж, давхардуулан газар олгосон болон хууль бус захирамжуудыг 2012 оны 7-р сард багтаан шийдвэрлэх** | Зөвлөмжийн биелэлт гаргаж ирүүлээгүй | Газар давхардуулан олгосон. ИТХ-ын шийдвэргүйгээр ОНӨ-ийг захиран зарцуулсан. АЗД-ын 2010 оны А-196 тоот захирамж | Тодорхой арга хэмжээ аваагүй |
| **Аймгийн ГХБХБГ-т, Мөрөн сумын газрын даамалд** | | | |
| **Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулан батлуулах** | Хөвсгөл аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг “газар дэлхий” ХХК шалгарч 2015 оны 2 дугаар сард төлөвлөгөөг АИТХ-д хүлээлгэн өгсөн. | Жишиг болгон мөрдөж байна. | Хэрэгжсэн |

| | | | |
|---|---|---|---|
| **Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг ГХБГЗЗГ-ын даргын 2010 оны 497-р тушаалаар баталсан “Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын дагуу боловсруулах** | Алаг-Эрдэнэ сумын 2015 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хийж сумдад жишиг болгож өгсөн.Үүний дагуу хийгдэж боломжтой. | | Хэрэгжсэн |
| **Эзэмшигч нь давхардаж байгаа, зориулалт бусаар ашиглаж байгаа газрын судалгааг гарган, асуудлыг хуулийн дагуу шийдвэрлүүлэх** | Иргэдийн дунд гарсан маргааныг хуулийн дагуу шийдвэрлэсэн.<br>Мөрөн сум ирэх онд тооллого хийж хуулийн дагуу шийдвэрлэнэ. | | Хэрэгжилт хангалтгүй |
| **Газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтыг журмын дагуу зохион байгуулж, иргэдийг шаардлагатай мэдээллээр хангах** | Мэдээллээр хангаж байна. | | Мэдээллээр хангаж байна. |
| **Мөрөн сумын ИТХ, Засаг даргад** | | | |
| **Газрын төлбөрийн хувь хэмжээг хууль, журамд нийцүүлэн шинэчлэн тогтоох ЗДТГ-т газрын төлбөр хураалтын мэргэжилтний ажлын байр нь шаардлагатай эсэхийг судлах, чиг үүргийг тодорхой болгох** | | | Хангалтгүй |
| **Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргад** | | | |
| **Орлогын тайлагналд газрын төлбөрийн орлого, дуудлага худалдааны орлогыг тус тусад нь тайлагнах** | 2014 онд газрын төлбөрийн орлого болон дуудлага худалдааны орлогын данс тусдаа, тусад нь тайлагнасан | Зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн | Орлогын дансдыг тусад нь гаргасан |
| **Татварын хэлтсийн даргад** | | | |
| **Газрын төлбөрийн ногдуулалт, төвлөрүүлэлтэд хуулийн дагуу хяналт тавин сумдын газрын даамлын улирал тутам тооцоо нийлж байх.** | Тайлан ирүүлсэн, тооцоо нийлдэг | Тооцоо нийлдэггүй, хяналт хангалтгүй | Хяналт хангалтгүй |

/Хавсралт -3/

Төлбөр төлөөгүй байгууллагын жагсаалт

/мянган төгрөг/

| № | Оноосон нэр | Баг | Газрын хэмжээ /га/ | Зориулалт | Ногдуулалт | 2013 он | 2014 он | 2015 он | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Инженерийн шугам сүлжээтэй төрийн захиргааны байгууллагууд** | | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **1** | Зэвсэгт хүчний 321 дүгээр анги | 13 | 1.99 | Батлан хамгаалах | 597.9 | 326.9 | 597.9 | 299.0 | 1223.8 |
| **2** | Ренчинжугнай эмнэлэг | 7 | 0.01 | Эмнэлгийн үйлчилгээ | 42.2 | | 42.2 | 21.1 | 63.3 |
| **3** | ОБЕГ-ын харьяа Хавсгал аймаг дахь Улсын нөөцийн салбар | 7 | 0.7 | Аж ахуйн конторын | 217.7 | | 151.9 | 76.0 | 227.9 |
| **4** | Соёл спорт аялал жуулчлал | 8 | 2.4 | Биеийн тамирын чийрэгжүүлэлт | 730.4 | | 697.4 | 348.7 | 1046.1 |
| **5** | Хүүхдийн төлөө хэлтэс | 8 | 0.49 | Хүүхдийн ордон | 147.0 | 97.4 | | 0.0 | 97.4 |
| **6** | Барилга 27 байр | 7 | 0.3 | Худалдаа үйлчилгээ | 104.3 | 104.3 | 104.3 | 52.2 | 260.8 |
| **7** | Хот тохижилт" ТӨХК | 7 | 0.36 | Нийтийн эдэлбэр | 108.6 | 108.6 | 108.6 | 54.3 | 271.5 |
| **8** | Мөрөн сумын ЗДТгазар | 7 | 0.38 | Битүүзах | 115.5 | | 115.5 | 57.8 | 173.3 |
| | **г.мДүн** | | | | **2063.6** | **637.2** | **1817.8** | **908.9** | **3363.9** |
| | **Аж ахуйн байгууллагууд** | | | | | | | | |
| **9** | Зам анги | 8 | 0.1 | Зочид буудал | 62.6 | 62.6 | 62.6 | 31.3 | 156.5 |
| **10** | Их үен ХХК | 13 | 0.55 | Худалдаа үйлчилгээ | 223.1 | 446.2 | 223.1 | 111.55 | 780.9 |
| **11** | Мэндээ блок | 7 | 0.1 | Үйлдвэр үйлчилгээ | 72.0 | 72.0 | 72.0 | 36.0 | 180.0 |
| **12** | Ц.Тогтох | 13 | 0.5 | Үйлдвэр үйлчилгээ | 117.3 | 117.3 | 117.3 | 58.65 | 293.3 |
| **13** | Үүрийн гэгээ white huose | 5 | 0.06 | Худалдаа үйлчилгээ | 50.4 | 100.8 | 50.4 | 25.2 | 176.4 |
| **14** | Хөвсгөл эх бараан зах | 5 | 0.8 | Захын үйл ажиллагаа | 351.8 | 351.8 | 351.8 | 175.9 | 879.5 |
| **15** | Увидас эмийн сан | 8 | 0.3 | Эмийн үйлчилгээ | 138.0 | 96.9 | 55.8 | 27.9 | 180.6 |
| **16** | Мон Ажнай | 8 | 4.9 | Нүүрс боловсруулах үйлдвэр | 19599.1 | 1459.1 | 19599.1 | 9799.55 | 30857.8 |
| **17** | Эрдэнэт хивс | 8 | 0.1 | Худалдаа, үйлчилгээ | 75.8 | 151.7 | 75.8 | 37.9 | 265.4 |
| **18** | Олонгол трейд ХХК | 7 | 7.9 | Барилга материалын үйлдвэр | 3195.2 | 2890.6 | 3195.2 | 1597.6 | 7683.4 |
| **19** | Жинчин | 8 | 0.08 | Худалдаа үйлчилгээ | 32.4 | 32.4 | 32.4 | 16.2 | 81.0 |
| **20** | "Тэсийнх" ХХК | 8 | 0.3 | Худалдаа, үйлчилгээ | 156.6 | 213.2 | 116.6 | 58.3 | 388.1 |
| **21** | Алтан мөчир хоршоо | 7 | 0.4 | Худалдаа, үйлчилгээ | 186.6 | 373.3 | 186.6 | 93.3 | 653.2 |
| **22** | Монгол Өндөр Тал | 8 | 0.9 | Худалдаа үйлчилгээ | 362.0 | 724.0 | 362.0 | 181.0 | 1267.0 |
| **23** | ЦагаанУул Тэрхэн | 5 | 0.6 | Захын үйл ажиллагаа | 254.8 | 309.7 | 254.8 | 127.4 | 691.9 |
| **24** | Спорт хороо батхүү хүүчин засаг | 8 | 0.6 | Соёл боловсрол | 242.0 | 484.0 | 242.0 | 121.0 | 847.0 |
| **25** | Хөвсгөл зочид буудал | 1 | 2.1 | Зочид буудал | 1585.6 | 1710.4 | 730.4 | 365.2 | 2806.0 |
| | **Дүн** | | | | **26705.3** | **9596** | **25727.9** | **12864** | **48187.9** |
| | **Төмс хүнсний ногоо болон үйлдвэр үйлчилгээ** | | | | | | | | |
| **26** | Дулаан харш Б.Мөнхсайхан | | 0.9 | Үйлдвэр үйлчилгээ | 363.8 | 471.6 | 23.5 | 181.9 | 677.0 |
| **27** | Монголын хүний хөгжлийн сан | 1 | 3 | Ногоон байгууламж, мод үржүүлэг | 300.0 | 600.0 | 300.0 | 150.0 | 1050.0 |
| **28** | Наранцэцэг | 9 | 0.1 | Дугуй хөрөө | 42.0 | 84.0 | 42.0 | 21.0 | 147.0 |
| **29** | Жамъянсүрэн | ГТХ | 0.7 | Төмс хүнсний ногоо тариалах | 71.7 | 143.4 | 71.7 | 35.85 | 250.95 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **30** | Баттулга | 10 | 1.02 | Төмс хүнсний ногоо тариалах | 102.2 | 102.2 | 102.2 | 51.1 | 255.5 |
| **31** | Гантөмөр | 13 | 0.9 | Төмс хүнсний ногоо тариалах | 97.8 | 97.8 | 97.8 | 48.9 | 244.5 |
| **32** | Мэндээ | Чим эди йнт олг ой | 0.5 | Мах боловсруулах үйлдвэр | 177.2 | 354.3 | 177.2 | 88.6 | 620.1 |
| **33** | Гэрэл | 1 | 0.6 | Шатахуун түгээх станц | 345.4 | 640.7 | 320.4 | 160.2 | 1121.3 |
| **34** | Цэнд-Аюуш | 13 | 1 | Төмс хүнсний ногоо тариалах | 100.0 | 200.0 | 100.0 | 50.0 | 350.0 |
| **35** | Дуламсүрэн | 13 | 1 | Төмс хүнсний ногоо тариалах | 100.0 | 200.0 | 100.0 | 50.0 | 350.0 |
| **36** | Бадамсүрэн | 13 | 1 | Төмс хүнсний ногоо тариалах | 100.0 | 200.0 | 100.0 | 50.0 | 350.0 |
| **37** | Цэрэндулам | 13 | 1 | Үйлдвэр үйлчилгээ | 300.0 | 600.0 | 300.0 | 150.0 | 1050.0 |
| **38** | Цэрэндулам | 13 | 0.5 | Үйлдвэр үйлчилгээ | 150.0 | 300.0 | 150.0 | 75.0 | 525.0 |
| **39** | Хоролсүрэн | 13 | 0.5 | Үйлдвэр үйлчилгээ | 150.0 | 300.0 | 150.0 | 75.0 | 525.0 |
| **40** | Намхайнямбуу | 13 | 10.3 | Аж ахуйн | 103.9 | 207.9 | 103.9 | 52.0 | 363.8 |
| **41** | Юмжирдулам | 13 | 1 | Төмс хүнсний ногоо тариалах | 100.0 | 200.0 | 100.0 | 50.0 | 350.0 |
| **42** | Батсуурь | 13 | 1 | Төмс хүнсний ногоо тариалах | 100.0 | 200.0 | 100.0 | 50.0 | 350.0 |
| **43** | Тэгшбаяр | 13 | 4.8 | Тэжээлийн ургамал тарих | 484.1 | 968.3 | 484.1 | 242.1 | 1694.5 |
| **44** | Ганзориг | 13 | 1 | Мод үржүүлэг | 100.0 | 100.0 | 100.0 | 50.0 | 250.0 |
| **45** | Анхбаатар | 1 | 1 | Аялал, жуулчилал | 300.0 | 300.0 | 300.0 | 150.0 | 750.0 |
| **46** | Галбадрах | 13 | 1.8 | Төмс хүнсний ногоо тариалах ХАА-н үйлдвэрлэл | 187.0 | 374.0 | 187.0 | 93.5 | 654.5 |
| **47** | Энхбаяр | 13 | 1 | Мод үржүүлэг | 100.0 | 100.0 | 100.0 | 50.0 | 250.0 |
| **Дүн** | | | | | **3875.1** | **6744.2** | **3509.8** | **1925.05** | **12179.05** |
| **Нийтдүн** | | | | | **32644.0** | **16977.4** | **31055.5** | **15697.9** | **63730.8** |

Мөрөн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2012 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн
26 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

Мөрөн сумын нутаг дэвсгэрийн газрын үнэлгээний бүсчлэлийн

газар эзэмших, ашиглах зориулалтын ангилал, 1м.кв газарт

ногдуулах газрын төлбөрийн хэмжээ

| д/д | Газар эзэмшилт, ашиглалтын зориулалт | 1-р бүс | | 2-р бүс | |
|---|---|---|---|---|---|
| | | 1 га газрын суурь үнэ 50 сая төгрөг | | | |
| | | Итгэлцүүр | 1м2 газрын төлөбр /төг/ | Итгэлцүүр | 1м2 газрын төлөбр /төг/ |
| 1 | Иргэний ахуйн зориулалт | 0,5 | 25 | 0,4 | 20 |
| 2 | Төсөвт байгууллага | 0,6 | 30 | 0,6 | 30 |
| 3 | Худалдаа бүх төрлийн үйлчилгээ | 0,8 | 40 | 0,6 | 30 |
| 4 | Аж ахуйн үйл ажилгаа /Худалдаа үйлчилгээнээс бусад/ | 0,8 | 40 | 0,6 | 30 |
| 5 | Нефтийн бүтээгдэхүүний агуулах, шатхуун түгээх станц | 1 | 50 | 1 | 50 |
| 6 | Автомашины граж | 1 | 50 | 0,8 | 40 |
| 8 | Дулаан холбоо эрчим хүч | 0,7 | 35 | 0,5 | 25 |
| 9 | Нисэх онгоцны буудал | - | - | 0,4 | 20 |
| 10 | Нам, төрийн бус байгууллага | 0,4 | 20 | 0,3 | 15 |
| 11 | Шашин, сүм, хийд | 0,5 | 25 | - | - |
| 12 | Бүх төрлийн үйлдвэрлэл /Хөдөө аж ахуйгаас бусад/ | 0,7 | 35 | 0,6 | 30 |
| 13 | Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл | 0,8 | 40 | 0,2 | 10 |

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
